

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-41

1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 4-13

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/ 13-14

3.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдлын талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох 14-41

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 18-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, Б.Бейсен, Г.Ганболд, Ц.Идэрбат;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Н.Ганибал;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор.

Нэг.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг, “Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетинг төслийн 4-р бүрэлдэхүүн байгууллагын хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын захирал Б.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг, “Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетинг төслийн 4-р бүрэлдэхүүн байгууллагын хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын захирал Б.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Болорчулуун, Ч.Ундрам, Б.Саранчимэг нар үг хэлэв.

Б.Саранчимэг: Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Саранчимэг: “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдлын талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн газрын дарга Б.Оюунсанаа, мөн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын шинжээч Э.Ариунням, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Эрдэнэсайхан, мөн албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн

бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Сүхбат, Нийслэлийн Байгаль орчны газрын дарга Г.Энхтайван, мөн газрын Ойн хэлтсийн дарга О.Тэмүүлэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн нар байлцав.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдлын талаарх мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Х.Болорчулуун, Ж.Бэт-Эрдэнэ, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч С.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдлын талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нарын хийсэн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 13 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,
Мягмар гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 10 цаг 21 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Саранчимэг: Эрхэм
гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг
айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх
нь хүрэлцэн ирж, ирц 57.9 хувьтай
болсон учир Байгаль орчин, хүнс, хөлөө
аж ахуйн байнгын хорооны 2023 оны 4
дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаан
нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д
заасны дагуу хуралдааны ирцийг та
бүхэнд танилцуулъя.

Тилеуханы Аубакир гишүүн Баян-
Өлгий, 2 дугаар тойрог ирсэн байна.
Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн
байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн
ирсэн байна. Наянтайн Ганибал гишүүн
ирж байна гэсэн. Гонгорын Дамдинням
гишүүн ирсэн байна. Гомпилдоогийн
Мөнхцэцэг гишүүн ирсэн байна.
Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн
байна. Батсүхийн Саранчимэг гишүүн
ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн ирсэн
байна. Цэвэгдоржийн Туваан ирсэн
байна. Одонгийн Цогтгэрэл ирсэн байна.
Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн ирсэн
байна. Төмөртөгоогийн Энхтүвшин
гишүүн ирсэн байна.

Та бүхэнд байнгын хороогоор
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгт, Органик бүтээгдэхүүний
тухай хуулийн шинэчилсэн найруулгын
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
төсөл байгаа. Улсын Их Хурлын гишүүн
Ундрэм нарын 7 гишүүн. 2023 оны 3
сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн
байгаа. Өнөөдөр бид нар хэлэлцэх эсэхийг
нь шийднэ.

Хоёрт, Байнгын хорооны
тогтоолын төсөл, “Гэрийн тэжээвэр
амьтны тухай хуулийн төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг
хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын
хэсгийг байгуулах” байгаа.

Гуравт, “Тэрбум мод” үндэсний
хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар
хотын ногоон байгууламжийн өнөөгийн
байдлын талаарх Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд. Нийслэлийн засан
дарга бөгөөд Улаанбаатар хотын
захирагчийн мэдээлэл сонсох байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж
хэлэх гишүүд байна уу? Санал хэлэх
гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл
хэлэлцэх асуудлаа баталлаа.

**Нэгдүгээр асуудал, Органик
бүтээгдэхүүний тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн төслүүд байгаа.**

Хууль санаачлагчийн
танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн
Ундрэм танилцуулна. Ундрэм таныг
урьж байна.

Ч.Ундрэм: Байнгын хорооны
дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2022 оны 6
дугаар сарын 17-ны өдрийн Хүнсний
хангамж аюулгүй байдлыг хангах талаар
авах зарим арга хэмжээний тухай 36
дугаар тогтоолд мал аж ахуй, газар
тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт,
тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл,
үйлчилгээнд стандарт, техникийн
зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх.
Хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний

чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, хоол, хүнсний зөв зохистой соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээнүүдийн хүрээнд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, баталгаат хүнсээр хангах асуудал үндэсний аюулгүй байдлын чухал хэсгийн нэг бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тогтоох, судалгаа шинжилгээний ажил эрчимтэй хөгжиж, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд үйлдвэрлэлийн чиг хандлагад өөрчлөлт орж байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүнийг дэмжиж байна.

Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ нь халдварт болон халдварт бус өвчний хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлтэй холбоотой ба Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар

зүйлийн 1 дэх заалт Хүн амьд явах эрхтэй гэсэн суурь зарчимд хамаарна.

Монгол Улсын хүн амын нас баралтад амьдралын буруу хэвшилээс үүдэлтэй зүрх судасны тогтолцоо, хавдар болон хоол боловсруулах эрхтний өвчин зонхилж статистик мэдээгээр 2021 оны байдлаар 65 хувийг эзэлж байна.

Хоол, хүнс өдөр тутмын хэрэглээ чанартай баталгаатай байна гэдэг нь биологи, хими, физикийн аливаа хорт бодисоор бохирдоогүй байх асуудал юм. Хүн зөв зохистой хооллох, хоол хүнсний баталгаажилт хаяг шошгын талаарх мэдээллийг авах органик үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих нь чухал юм.

Хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгааны дүгнэлтэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, тэжээллэг, хүнд ээлтэй байгалийн гаралтай органик үйлдвэрлэлийг дэмжих олон нийтэд сурталчлах мэдлэгийг сайжруулах, органик брэнд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох чадвартай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эд боловсруулах, баталгаажуулах, хяналт тавих, бүртгэл мэдээллийн сан байгуулах тогтолцоо бүрдүүлэх нь хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдэнэ.

Манай улс 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилт тавьсан. Манай улсад 2022 оны байдлаар 715 органик бүтээгдэхүүнийг 348 органик үйлдвэрлэл эрхлэгч үйлдвэрлэсэн бөгөөд www.organic.mofa.gov.mn сайтад бүртгүүлсэн байна.

Эдгээр органик бүтээгдэхүүний дийлэнх хувийг газар тариалангийн бүтээгдэхүүн эзэлж байгаа ба чанар орлогын хэмжээ харилцан адилгүй. Өнөөдрийн байдлаар албан ёсны тооцоо судалгаа гараагүй байна. Мөн иргэд органик бүтээгдэхүүний ашиг тусыг

ойлгох нь дутмаг, дэмжлэг урамшууллын тогтолцоо хангалтгүй, органик брэнд бүтээгдэхүүний эрх зүйн таатай орчин бүрдэхгүй байгаагаас шалтгаалан төдийлөн хөгжиж чадахгүй байна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50 хуваас дээш хэсэгт өөрчлөлт орсон тул шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсрууллаа.

Органик хүнсний тухай хууль гэснийг Органик бүтээгдэхүүний тухай хууль гэж зохицуулах харилцаа хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөн эх орны үйлдвэрлэлийн органик бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлсэн болно.

Хуулийн төсөл нь 5 бүлэг 18 зүйлтэй. 1 дүгээр бүлэг. Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, органик үйлдвэрлэлийн зарчим,

2 дугаар бүлэг. Органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйлс,

3 дугаар бүлэг. Органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, баталгаажуулалтын байгууллагын үүрэг, шошгололт, бүртгэл мэдээлэл,

4 дүгээр бүлэг. Органик бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг урамшуулал,

5 дугаар бүлэг. Органик үйлдвэрлэл органик бүтээгдэхүүнд тавих хяналт хариуцлагын тогтолцоог тус тус тусгаж өглөө.

Органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдсанаар байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй органик үйлдвэрлэлийг дэмжин зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, бүс орон нутгийг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгох, органик хүнс,

бүтээгдэхүүнээр хүн амаа хангах, экспортод гаргах боломж бүрдэх юм.

Ингэснээр Нэгдсэн Үндэстний байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт 2030 болон Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”-д дэвшүүлсэн зорилтуудад хүрэх юм.

Байнгын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Саранчимэг: Ундрам гишүүнд баярлалаа. Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Тунгалаг Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Органик хүнс, хүнсний сав баглаа, боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч, Алтанцэцэг Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл маркетинг төслийн 4 дүгээр бүрэлдэхүүний хэсгийн менежер ирсэн байна.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү. Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Болорчулуун гишүүн асуултаа асууя.

Х.Болорчулуун: Ундрам гишүүнээс Органик бүтээгдэхүүний тухай хууль гэж оруулж ирж байна. Органик хүнсний тухай хууль гэж явж байсан яагаад Органик бүтээгдэхүүн гэж болов? Хэрэв Органик бүтээгдэхүүн гэвэл маш өргөн хэмжээнд болно. Зөвхөн хүнсээр тогтохгүй, арьс шир, ноос ноолуур гээд л цааш явна шүү дээ. Тэгэхээр хэтэрхий өргөн хэмжээтэй болчих юм биш үү гэж хэлэхээр байна.

Органик хүнс гэдэг бол бас өргөн агуулгаар хэрэглэгддэг олон улсад. Өөрөө сая хэллээ органик бүтээгдэхүүнд бол

ихэвчлэн газар тариалангийн бүтээгдэхүүн байна гээд. Тэгэхээр хүнс гэдгээрээ яагаад явахаа больсон юм бэ гэдгийг нэгт асууя.

Хоёрдугаарт манай Монгол Улс бол бас органик хүнс хэрэглэх бүрэн боломжтой. Газар хөрсний өгөөж, баялаг. Гэтэл бид нар өнөөдөр химийн бодис гербицид, пестицид бохирдсон хүнсний зүйл гаднаас авч байна. Ялангуяа гений өөрчлөлттэй хүнс буюу гето хүнсийг гаднаас их авч байна. Уг нь энэ рүүгээ чиглэсэн энэний эсрэг Органик хүнсний тухай хууль байх нь зүйтэй байсан биш үү? Органик хүнснийхээ хуулийг бүтээгдэхүүнийхээ хуулийг энэ ялангуяа сүүлийн жилүүдэд химийн хор гербицидээс илүү гений өөрчлөлттэй хүнс гэдэг бол аажимдаа олон жилийн дараа хүний өвчлүүлэхээс гадна үр удамд хүртэл нөлөөлөхийг олон улс бүүр судалгаагаараа тогтоочихсон шүү дээ. Энэ тал дээр энэний эсрэг Органик хүнсний энэ хууль чинь ер нь ямархуу зүйл, заалт дээр нь орж ирж байгаа юм бэ? Би бол бүтээгдэхүүн гэхээсээ илүү органик хүнс гэдгээсээ яваасай гэж байна хэлэхээр байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Ундрам гишүүн хариулъя.

Ч.Ундрам: Ерөнхийдөө бид нар Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилт энэ хууль маань хэрэгжээд 5 жил болж байгаа. Тэгээд хэрэгжилт нь хэрхэн явагдсан бэ гээд үнэлгээ хийсэн байгаа. Мөн салбарын хүмүүстэй маш олон хэлэлцүүлэг хийсэн байгаа. Тэгээд эндээс бид нар салбарын үйлдвэрлэгчид юу ярьж байгаа вэ гэхээр органик бүтээгдэхүүн бол ганцхан хүнсээр хязгаарлагдахгүй бид нар Монголоос үйлдвэрлэж болох ноос ноолуур, арьс шир, ноосон утас, малын дайвар бүтээгдэхүүнүүд, гоо сайхан, уламжлалт эм бэлдмэл гэх мэтчилэн маш өргөн хүрээнд бид нар органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломж байна.

Тэгэхээр энийгээ энэ хуульдаа хамруулж өгөөч. Ингэснээр бид нар энэ хууль хэрвээ батлагдаад хэрэгжих юм бол тодорхой хэмжээний төрийн дэмжлэг, хөшүүргүүд бий болоод энийгээ эргээд экспортлоход маш их хэрэгтэй байна гэсэн ийм асуудлууд тавигдсан.

Тэгээд энийг бол ажлын хэсэг дээр бид нар яриад үнэхээр бид нар органик бүтээгдэхүүн манай Монгол Улсад гоо сайхны бүтээгдэхүүн гэхэд маш олон брэндүүд гараад, эхнээсээ танигдаад ер нь экспортлох хэлэлцээрүүд ч гэсэн хийгдээд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ арьс шир, гоо сайхны бүтээгдэхүүнүүдээ ч гэсэн энэ хуульдаа оруулж, дэмжиж өгөх нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Хоёрдугаарт энэ гений өөрчлөлттэй бүтээгдэхүүний эсрэг энэ хууль бас тодорхой хэмжээнд үйлчилнэ гэж бодож байна. Энэ Органик бүтээгдэхүүний тухай хуулиар бид нар энэ органик бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдийг нэг талаас дэмжинэ. Нөгөө талаас органик бүтээгдэхүүний хэрэглээг олон нийтэд сурталчилж өгнө гэж үзэж байгаа. Ингэснээр хүмүүс бусад органик бүс бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгана гэж үзэж байгаа.

Яг энэ гений өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг хориглогч юм уу тодорхой заалтуудыг нэгдүгээрт Хүнсний тухай хууль, хоёрдугаарт бусад экспорт, импорт, татварын бодлого гэх мэтчилэн бусад бодлогоор зохицуулах ёстой байх гэж үзэж байна. Тэгээд энэ дээр манай бас ажлын хэсгээс нэмэлт хариулт байвал хэлэх байх.

Б.Саранчимэг: 1 номерын микрофоныг өгье. ажлын хэсэг нэмж хариулна. 1 номерын микрофоныг өгье. Дараад хэрэггүй шүү. 1 номер болохгүй байх шиг байх юм. 3 номерын микрофоныг өгье. 3 номер руу шилжээд суучих. 3 номер уу? Өөрийгөө танилцуулаад тэгээд асуултад хариулчхаарай.

Д.Тунгалаг: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Тунгалаг.

Болорчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өргөн барьж байгаа Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.1.5-д хувиргасан амьд организм, түүнээс гаралтай түүхий эд бүтээгдэхүүн болон өсөлтийн даавар ашиглахыг бол органик үйлдвэрлэлд хориглож байгаа. Тэгэхээр органик бүтээгдэхүүн, гений өөрчлөлттэй бүтээгдэхүүн 2 бол хоорондоо хэзээ ч хамт байдаггүй. Эсрэг тийм зохицуулалттай ийм 2 бүтээгдэхүүний ангилал юм.

Тэгэхээр төслийн 7.1.5-д хувиргасан амьд организмтай буюу гений өөрчлөлттэй бүтээгдэхүүн, өсөлтийн даавар, түүхий эд ашиглахыг хориглоно гэж зааж өгсөн байгаа. Баярлалаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд тодруулъя.

Х.Болорчулуун: Би түрүүнд хэлсэн Органик хүнсний тухай хууль гэж яригдаж байснаа Органик бүтээгдэхүүний тухай хууль гэж гараад ирлээ. Тэгэхээр энэ бол яг хүнснээс тэр эд материаллаг бүтээгдэхүүнийг салгаж хуульчлах нь зүйтэй л дээ. Хүнс гэхэд тусдаа, аль аль нь тусдаа ер нь том салбар гэж хэлж болно. Хүнсний аюулгүй байдлын тухай хууль дээр бол тэр гений өөрчлөлттэй хүнс, хувиргасан амьд организмын тухай бол нэмэлтээр орохоор Их Хурал дээр байж байгаа. Яг тэр шиг Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль тэр органик бүтээгдэхүүнийг их том бүлэг болгоод оруулчихвал яг энэ гений өөрчлөлттэй хүнстэйгээ хамт зүгээр гэж санагдаж байна. Тэрнээс биш яг ингэ материаллаг зүйлтэй хүнсээ холиод ерөнхий одоо.../минут дуусав./

Б.Саранчимэг: Санал хэллээ гэж ойлгож байна. Дараагийнх Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Бид энэ органик хүнсний асуудлыг ер нь орхигдуулж болохгүй. Цаашид улам өргөжүүлээд авч явах хэрэгтэй. Гэхдээ энэ хуулийн хүрээнд бас бараа бүтээгдэхүүн болоод бас ингээд тухайн орчин нөхцөлүүдийг бас ахиулж байгаа юм байна гэж ингэж харагдаж байгаа.

Ер нь мэдээж хүнсгүйгээр хүн бол хаашаа ч явах боломж байхгүй. Зөвхөн зүрх судасны өвчлөл гэхэд л нийт өвчлөлийн энэ хүнснээс болоод 65 хувийг нь эзэлж байна гээд л ингээд л та бүгдийн энэ гаргаж ирсэн судалгаан дотор байж байна.

Тэгэхээр ер нь бид нар энэ хорт хавдар ихсэж байгаа энэ цаг хугацаанд ер нь хүнсээ чухалчлах нь зөв юм Тэгэхээр энэ хуулиар ер нь бол бас яг эрэмбэлж оруулж ирэх нь зүйтэй юм болов уу гэж ингэж харагдаж байна. Бид нар тэртээ тэргүй хэзээнээсээ хөдөө аж ахуй, мах сүүгүйгээр бид нар хаашаа ч явахгүй.

Тийм учраас энэ нэгдүгээрт энэ газар тариалангийн бүтээгдэхүүнүүдийг бас эрэмбэлээд оруулаад ирж байгаа нь нэг талаасаа зөв. Гэхдээ дараа нь энэ мах сүүний асуудлуудыг бас бас оруулж ирэх нь бас зүйтэй гэж ингэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татвараар дэмжих нь ер нь бол гол энэ хуулийн маань бас бодлогын нэг хэсэг нь юм шиг байна. Хамгийн том асуудал нь юм шиг байна.

Тэгэхээр энэ дээр ямар байдлаар зохицуулалт хийх гэж байгаа юм бэ? Тооцоо, судалгаатай үйлдвэрлэлийг дэмжих энэ хөрөнгө оруулагчдыг энэ салбар руу татах тал дээр бас ямар бодлогыг энд бас тусгаж оруулж ирж байгаа юм бэ гэдэг зүйлийг асууя гэж ингэж бодож байна.

Тэгээд аж ахуй нэгжүүд хүн амын орлогын татварын татвараас 90 хувийг нь чөлөөлнө гээд ингээд энэ хууль дотроо бас заагаад оруулаад ирсэн байх шиг байгаа юм. Ийм бололцоо, нөхцөл нь бас байгаа юм уу, үгүй юм уу? Ер нь судалгааг хэр хийсэн юм бэ гэдэг талаас энэ зүйлүүдийн асуултуудын хариулт авъя.

Б.Саранчимэг: Ундрам гишүүн хариулъя.

Ч.Ундрам: Мөнхцэцэг гишүүнтэй санал нэг байна. Манай улс бол хөдөө аж ахуйн улс. Ер нь бол хэдийгээр өнөөдрийн эдийн засгийн дийлэнх хувийг уул уурхайн салбар эзэлж байгаа ч гэсэн хөдөө аж ахуйн салбар манай уламжлалт бөгөөд цаашид ч гэсэн хөгжихөд хамгийн гол салбар гэж бодож байгаа.

Энэ Органик бүтээгдэхүүний тухай хуульд яг энэ мал аж ахуйтай холбоотой асуудал нэлээн хамрагдах юм байгаа юм. Ялангуяа энэ мах, сүү тэгээд бид нар энэ хамрах хүрээг нь өргөжүүлснээр арьс шир, ноосны асуудал ч гэсэн энэ хуульд ороод манай малчдад нэлээн дэмжлэг үзүүлэхээр хууль болж ирж байгаа юм.

Тэгэхээр хэрвээ малчид маань өөрсдийнхөө үйлдвэрлэж байгаа мах, сүүг органик гэдэг баталгаажуулалтаа хийчих юм бол гадаад улсад илүү өндөр үнэ өртгөөр экспортлох, органик гэдэг. тэр шошгын хүрээнд экспорт хурдлах боломж нь нэгдүгээрт бүрдэж байгаа.

Хоёрдугаарт бид нар олон дэмжлэгүүдийг оруулж ирснийг та бас сая хэллээ. Үүний 1 нь жишээлбэл бид нар хүн амын орлогын албан татварын 90 хувийг нь хөнгөлөх, аж ахуй нэгжийн орлогын албан татварын 90 хувийг хөнгөлөх, төрийн худалдан авалт хийх юм бол давуу эрх олгох Ерөнхий боловсролын сургуульд үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлдэг болсон байгааг бид бүгд бүгд мэдэж байгаа. Энэ дээр илүү органик хүнсийг дэмжиж, хэрэглэх

чиглэлийн энэ хөшүүргүүд, мөн манай энэ салбарын яам нь энэ органик бүтээгдэхүүнийг илүү сурталчлах, мөн олон улсад экспо болон үзэсгэлэн худалдаанд органик хүнс үйлдвэрлэгчдийг оролцуулах, олон улсад экспортлоход 2 орны тэр баталгаажуулалтын процессыг хүлээн зөвшөөрүүлэх гэх мэтчилэн энэ үүргүүдийг өгч байгаа юм.

Яг өнөөдрийн байдлаар манай Монгол Улсад энэ Органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлж байгаа ерөөсөө 2-хон мэргэжилтэн Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр ажилладаг. Тэгээд бусад бүх нэгж аймгийн Засаг даргын Тамгын газарт ч юм уу энэ органик хүнсийг хариуцаж байгаа мэдэж байгаа, ойлгож байгаа, хэрэгжүүлчих юм сан гэж явж байгаа хүн ерөөсөө байхгүй байгаа.

Гэтэл бид нар өөрсдөө бид нар органик хүнс хэрэглэдэг, эрүүл хүнс хэрэглэдэг гээд яриад байдаг. Үүнийгээ яг бүрэн баталгаажуулж байгаа юм ерөөсөө байхгүй. Малдаа хэрэглэж байгаа энэ вакцин, эм тариа нь ч гэсэн чанарын шаардлага хангахгүй байгаагаас болж органик хүнсээ бид нар экспортолж, хүлээн зөвшөөрүүлж, үнэтэйгээр зарж чадахгүй байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг бид нар хэрэгжүүлснээр манай малчдын мах, сүүгээ илүү өндөр үнэтэйгээр арилжаалах, цаашилбал экспортлох энэ боломж нь бүрдэнэ гэж бодож байна.

Манай ажлын хэсгээс бас нэмж хариулах байх.

Б.Саранчимэг: 2 номерын микрофон нэмж хариулъя гэж байна. Ажлын хэсэг.

Б.Алтанцэцэг: Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хэрэгжүүлж байгаа төслийн менежер.

Энэ хуульд бид нар мал аж ахуй, газар тариаланг хамруулж оруулсан байгаа. Энэ нь хуулийн төслийн 4.1.1 дээр

органик үйлдвэрлэл гэж юуг хэлэх вэ гэдгийг томъёолсон. Органик бүтээгдэхүүний анхан шатын үйлдвэрлэл эрхлэх, бэлтгэх, боловсруулах, савлах, хадгалах, тээвэрлэх, худалдаалах үе шатад энэ хуульд заасан шаардлагад нийцсэн арга технологийг ашиглаж үйлдвэрлэл явуулж байгаа, энэ үйлдвэрээс гарч байгаа бүх бүтээгдэхүүн бол баталгаажуулсны дараа органик болно гэсэн байгаа.

Тэгэхээр зэрэг энэ дотор зөвхөн газар тариалан биш ч мал аж ахуй бас ороод явж байгаа. Дээрээс нь байгалийн зэрлэг жимс, мөөг, самар гэх мэт бүтээгдэхүүнүүд бас баталгаажуулагдах юм бол органик байх магадлалтай.

Яг өнөөдрийн байдлаар тариалангийн гаралтай, тариалангийн үйлдвэрлэлд илүү органик үйлдвэрлэл нэвтрээд явж байгаа гэдгийг онцолсон байгаа.

Татвартай холбоотой асуулт дээр хуулийн төслийн зардлын тооцоог судлаач мэргэжилтнээр хийлгэсэн байгаа. Үүн дээр бол тэр энэ хуулийн төсөлд дагаж орж байгаа хүн амын орлогын болон, аж ахуй нэгж эсийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ хүрээнд бол төсөвт тодорхой мэдээжийн хэрэг мөнгө гарна.

Гэхдээ илүү экспортод гаргаад юм уу, эсвэл органик үйлдвэрлэл хөгжсөнөөрөө хүн амын эрүүл мэндэд эзлэх, нөлөөлөх нөлөө нь илүү гэдгийг тооцоолж гаргасан байгаа. Баярлалаа.

Өнөөдрийн байдлаар хөдөө аж ахуйн тариалангийн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд татварын хүн амын болон орлогын албан татварыг 50 хувь хөнгөлж байгаа. Тэгэхээр зэрэг органик үйлдвэрлэл бол ердийн үйлдвэрлэл буюу конвенционал үйлдвэрээс бол илүү нарийн нягт ажиллагаа

шаарддаг, пестицид химийн гаралтай бордоо болон гений өөрчлөлттэй хүнс, цацрагийн боловсруулалт гэх зэрэг зүйлийг хэрэглэхийг хориглодог. Энэ утгаараа дэлхийн улс орнууд бол органик үйлдвэрлэлд ямар нэгэн байдлаар дэмжиж явдаг байгаа.

Ийм учраас бид нар олон улсын бас энэ туршлагыг судалсны үндсэн дээр энэ 90 хувийг оруулж ирсэн байгаа.

Б.Саранчимэг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Болорчулуун гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн саналаа хэлье.

Т.Аубакир: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хууль бол бас цаг үеэ олсон ийм хууль орж ирж байгаа юм. Орчин үед зөвхөн гадаадынхныг органик хүнсэндээ ач холбогдол өгөөд органик хүнс хэрэглэдэг юм байна шүү дээ, ямар мундаг юм бэ гээд гайхаад суухынхаа оронд бид нар бас хууль, эрх зүйн орчин нь бүрдүүлж өгөх ёстой л доо.

Одоо манай Монгол Улсын иргэд зөвхөн залуу гэр бүл гэлтгүй нийт иргэд маань органик, цэвэр бүтээгдэхүүн хүнсэндээ хэрэглэе. Үр хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд анхааръя, өөрсдийнхөө эрүүл мэндэд анхааръя. Энийг нь төр засгаас дэмжээд бид нарыг органик цэвэр хүнсээр, энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой хангаж өгдөг, анхаарал тавьдаг төр засаг байгаа болов уу гээд ингээд хүлээж байгаа үед бид нар ямар ч байсан эрх зүйн орчинтой болж байгаа нь талархууштай зүйл. Энийг ялангуяа салбарын яам дэмжих ёстой.

Идэж ууж байгаа хоолноосоо үндсэндээ өвчин олж авдаг тохиолдол энэ чинь газар авлаа шүү дээ. Тийм учраас бид нар энийг нүдэн балай, чихэн дүлий ингээд байгаад байж болохгүй. Бид нар ч гэсэн өдөр тутамдаа хэрэглэж байгаа дэлгүүрийн лангуун дээрээс худалдаж авсан төмс худалдаж авахдаа

хүртэл энэ ер нь ямар бордоо хэрэглэсэн юм бол, химийн хольцтой юм уу, энэ яг цэвэр органик болов уу, энэ байцай авахдаа бид нар энэ Хятадын байцай юу, Монгол байцай юу гээд захын лангуун дээр хүртэл үнэн ялгаатай байдаг шүү дээ.

Энэ чинь өөрөө ард иргэдийн бид нар органик, цэвэр хүнс хэрэглэх юм сан гэсэн эрэлт байгаад байгааг харуулж байгаа юм. Энэ эрх зүйн орчин энэ хууль батлагдсанаараа тэр органик хүнс үйлдвэрлэгчдийг дэмжих, тэд нарыг мотивацижуулах, бид нар зөвхөн гадаадын юмыг хараад гайхаад шагираад ямар сайхан юм бэ гээд суух биш энэ Улсын Их Хурлын хийх ёстой л ажил. Ялангуяа манай Байнгын хорооны хийх ёстой ажил.

Тийм учраас энэ хуулийн төслийг бид нар дэмжээд явах нь зүйтэй. Бид нар үр хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд анхаарал бид нар л тавихгүй юм бол хөрш улс Хятад, Орос 2 ирээд бид нар анхаарал тавихгүй шүү дээ.

Мэдээж хэрэг хууль өргөн барьж байгаа нь зөв. Алдаж, засаад залруулаад явах ёстой зүйлүүд бий. Тэгэх гэж л энэ Улсын Их Хурал буюу энэ мэтгэлцээний талбарт оруулж ирж байгаа зүйл гэж би ойлгож байгаа.

Тийм учраас энэ хуулийг бид нар дэмжээд салбар салбарын хүмүүс байж байна, эрүүл мэндийн салбарынх байж байна, хүнсний салбарынхан байж байна. Бид нар салбар салбарынхаа мэдлэг чадвараа энэ дээр харуулаад энэ хуулийг дэмжээд явах ёстой. Энэ хуулийн гол зорилго бол энэ органик хүнс үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчид, газар тариалан эрхлэгчид, мал аж ахуй эрхлэгчид, бусад төрлийн хүнс үйлдвэрлэгчид дээр бид нар энэ эрх зүйн орчныг нь, татварыг нь таатай нөхцөлөөр дэмжиж өгч байгаад гол энэ хуулийн концепт байж байгаа.

Бид нар ороод ирэхэд нь цаашаа ингээд түлхээд унагаах биш алив аваад

үзээдэхье, болохгүй байгаа юман дээр бид нар саналаа хэлье, дэмжээд явах зүйл юу байна, наадах чинь нээрээ л хүний эрүүл ахуй, амь настай холбоотой зүйл учраас энийг Монгол Улс хэзээ нэгэн цагт ийм хуультай болох ёстой байсан юм. Бид нар хийхгүй ч гэсэн хойч ирээдүй хийнэ.

Тийм учраас энэ хуулийг оруулж ирээд ямар ч байсан эрх зүйн орчинтой болгоод энэ органик хүнс үйлдвэрлэгчид, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг эрх зүйн орчинтой болгоход энэ хуулийн хууль санаачлагчдын гол зорилго байгаа. Тийм учраас энэ хуулийг дэмжээд гаргаач гэж хүсэж байна.

Б.Саранчимэг: Аубакир гишүүнд баярлалаа. Болорчулуун гишүүн саналаа хэлье.

Х.Болорчулуун: Би бол хуучин Органик хүнсний тухай хууль гэж явж байсан тэрүүгээр нь дэмжиж байсан. Органик бүтээгдэхүүн гэхээр чинь хүнсний салбар, хөнгөн аж үйлдвэрийн салбар 2 тусдаа 2 том салбар шүү дээ. Органик бүтээгдэхүүн гэхээр чинь би түрүүн хэлсэн шүү дээ арьс ноос, ноос ноолуур гээд бүгд л орчихно. Тэгэхээр энэ чинь бол нөгөө бүтээгдэхүүн гээд ингээд нэр нь бас болохгүй байна. Хэтэрхий бас ерөнхий том болчихож байна. Хүнсээ хэн ч гэсэн органик хүнс цэвэр, эко хүнс хэрэглүүлэхийг бодож байгаа шүү дээ. Тэгэхээр энэ талаасаа нэрийг нь бол бүтээгдэхүүн биш органик хүнс гэдгээрээ явах нь зүйтэй. Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт томоор гений өөрчлөлттэй хүнстэй адилхан бүлэг оруулж болох л байсан юм. Тэгэхэд тусдаа Органик хүнсний хууль гэхэд болохгүй юм бол байхгүй.

Гэхдээ бүтээгдэхүүний хууль гэж ингэж орж ирвэл нь наадах чинь хэтэрхий өргөн агуулгатай болоод зорилго нь бас хазайх юм болно гэдгийг бас хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ органик хүнсийг татвараас тэгнэ ингэнэ 90 хувь хүртэл чөлөөлнө гэж байна. Үүнийг зөвхөн Засгийн газар оруулна шүү дээ. Гишүүний санаачилсан хуулиар тэр татварын асуудал хөндөгдөхгүй байхгүй юу. Тэгэхээр наадхыгаа буцаагаад, нэрийг нь яагаад яг тэр хүнс рүүгээ чиглэсэн органик хүнсний хуулийг чамбайруулж оруулж ирэх нь би зүйтэй л гэж хэлэх байна.

Тэгэхгүй бол ерөнхий зорилго, чиглэл маань сулраад ингээд явчих ийм осолтой зүйл болох вий л гээд.

Б.Саранчимэг: Ундрам гишүүн саналаа хэлье гэсэн. Нэр нь ороогүй байх юм.

Ч.Ундрам: Энэ органик бүтээгдэхүүний тухай хуулийн бас хамгийн гол хэсэг нь угаасаа хүнсний асуудал байгаа. Тэгэхээр та бүхэн маань хэлэлцэх эсэхийг нь шийдээд өгөх юм бол энэ хуулийг ажлын хэсэг гарч ажиллаад, боловсруулалтын явцад яг хүнсний гэдэг цар хүрээнийх нь хэмжээнд ч гэсэн энийг улам сайжруулаад, чамбайруулаад явах бүрэн боломжтой гэж бодож байгаа.

Угаасаа өнөөдөр манайд үйлдвэрлэж байгаа ихэнх бүтээгдэхүүн нь ерөөсөө энэ хүнсний салбартай, тэгээд энэ бордоо эд нар гээд. Яг энэ чиглэлтэй бол илүү холбоотой байгаа л даа манай үйлдвэрлэл.

Цаашид бид нар бас энэ хүнсний салбар нь илүү бас сайжраасай гэж хүсэж байгаа. Бүтээгдэхүүн гэж оруулж ирсэн нь би түрүүн хэлсэн одоо жишээлбэл маш олон эмэгтэйчүүдийн ажлын байраар хангаж байгаа энэ гоо сайхны салбар байгаад байна. Цаашилах юм бол бид нар экспортод органик гэдэг шошгын доор илүү үнэд хүргэж болохуйц энэ арьс шир, ноос ноолууртай холбоотой салбарууд байгаа учраас бид нар цар хүрээг нь ерөнхийдөө ингэж өргөсгөж өгсөн байгаа юм.

Тэгээд манай Хөдөө аж ахуйн яам ч гэсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гээд ганцхан хүнсний салбар биш нийт энэ хөнгөн үйлдвэрийн асуудлыг ч гэсэн хариуцаж байгаа болохоор заавал энэ органик хоол хүнс нь энэ, органик бусад ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн нь энэ гэдэг ийм тусдаа хууль заавал байх албатай юм уу, үгүй юү гэдгийг бид нар бас эргэцүүлж бодох ёстой байх гэж бодож байна.

Энэ хууль нэгдүгээрт Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль юм. Хүний амьд явах эрхтэй гэсэн энэ суурь эрхийг хангахад чиглэсэн нэгдүгээрт хууль.

Хоёрдугаарт. Энэ бол манай улсын эдийн засагтай холбоотой хууль юм. Энэ хууль батлагдсанаар бид нар эдийн засгаа солонгоруулах, экспортоо нэмэгдүүлэх, энэ төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэхүйц ийм зүйлүүд бий болохоос гадна бас аялал жуулчлалын Монголыг чинь байгалийн, натурал, органик гэж гаднынхан хардаг. Хүрч ирээд яг энэ баталгаажуулалтаар орчихсон органик хүнстэй хоолоор дайлах ч байдаг юм уу, органик бүтээгдэхүүнүүд энэ хүмүүст өгөх гэх мэтчилэн бас аялал жуулчлал гээд олон салбарт холбоотой.

Үүнээс гадна манай бас байгаль орчинтой холбоотой, хөрсөө хамгаалж хайрлах гээд маш олон салбаруудыг хамарсан ийм чухал хууль юм. Тийм учраас эрхэм гишүүд та бүхэн маань хэлэлцэх эсэхийг нь шийдээд тэгээд энэ дээр ажлын хэсэг гараад яг цар хүрээг нь ямар хэмжээнд байлгах юм гэдгээ шийдээд явах бүрэн боломжтой гэж үзэж байгаа юм. Баярлалаа.

Б.Саранчимэг: Өнөөдөр маш чухал хуулийн төслийг бид нар хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлахад бас миний бие оролцсон. Маш олон судалгаанууд хийгдсэн. Олон

улсын байгууллагуудтай бас ажиллаж байж энэ хуулийн төслийг өргөн барьж байгаа.

Тэгэхээр өнөөдөр энэ хүнсний аюулгүй байдал гэдэг бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг яах аргагүй байгаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ санаачилсан Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлыг бас Улсын Их Хурал дээр Байнгын хороонд бид нар хэлэлцээд, 36 дугаар тогтоолыг баталсан. Энэ дагуу холбогдох хуулиуд орж ирэх ёстой. Хуулийн төслүүдийг хэлэлцэх ёстой. Тэгээд тэр хүрээнд ч гэсэн бас энэ хууль маань орж байгаа гэдэгт би бас итгэлтэй байна.

Энэ 2016 онд Органик хүнсний тухай хуулийн энэ шинэчилсэн найруулж, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, энэ баталгаажуулах, мөн бүртгэх, органик энэ болохыг нь илэрхийлсэн тэмдэг хэрэглэх, сурталчлах, худалдаалах, органик үйлдвэрлэл эрхлэгчид дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбогдсон энэ харилцааг зохицуулахаар энэ уг хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байгаа учраас эрхэм гишүүд та бүгдийг бас энэ хуулийн төсөлтэй танилцсан гэж итгэж байна. Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, тэгээд цаашидаа ажлын хэсэг дээрээ бид нар дахиад ярих бүрэн боломжтой учраас бас энэ саналыг хэлж байна.

Тэгээд санал хураалт. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дунг танилцуулъя. 90 хувиар Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэж гишүүд үзлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнийг Дамдинням гишүүнийг томилж байна. Энэ асуудал дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

10.55 цаг

Хоёрдугаар асуудал бол Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах байгаа.

Гишүүдийн ирсэн саналыг та бүхэндээ танилцуулъя. Тэгээд дараа нь санал хураалт явагдана.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Цогтбаатар гишүүн. Гишүүдээр Аубакир гишүүн, Батишугар гишүүн, Дамдинням гишүүн, Туваан гишүүн байгаа. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт орж байгаа Цогтбаатар даалгасугай гэж байна.

Санал хураалт. Дэмжье гэсэн саналаар.

Протоколоор Аубакир гишүүнийг дэмжсэнд тооцоорой. Энэ техник нь ажиллаагүй байна.

90 хувийн гишүүдийн саналаар энэ ажлын хэсэг батлагдлаа. Дараагийн асуудалдаа оръё.

10.57 цаг

Гуравдугаар асуудал. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн өнөөгийн байдлын талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэдээллийг сонсох байгаа.

Ажлын хэсгийнхнийг зааланд урьж байна. Ажлын хэсэг нь хаана байна?

Эхлээд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын танилцуулгыг сайд Бат-Эрдэнэ танилцуулна. 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм байнгын хороон дарга болон Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ байна.

Монгол орны ойн мөнх цэвдэг ус чийгийг тогтоон барих, гадаргын усны горимыг зохицуулах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, ургамал, амьтны амьдрах таатай орчныг бүрдүүлэх зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хамгааллын өндөр ач холбогдол бүхий эмзэг тогтоцтой онцлог эко системд тооцогддог. 2020 оны байдлаар ойгоор бүрхэгдсэн талбай 7.9 хувийг эзэлж байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах, мөн Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах

зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх талаар Засгийн газарт чиглэх тухай 58 дугаар зарлигийг 2021 оны 10 сарын 4-ний өдөр гаргасан.

Ойн тухай хуульд 2022 оны 6 дугаар сард өөрчлөлт орж Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 272 тоот тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар 38 орон тоотой байхаар баталсан.

Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 10 сарын 13-ны өдрийн А/418 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд 27 үйл ажиллагаа, 154 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хэлэлцүүлэн батлуулж, Уур амьсгалын Үндэсний хорооны хурлаар 3 дугаар сарын 14-ний өдөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулсан.

2022 оны байдлаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж буй аж ахуй нэгжүүд манлайлан хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж, 21 аймаг, нийслэлд нийт 680 сая, уул уурхайн томоохон 21 аж ахуй нэгж 608 сая, банк, санхүүгийн байгууллага болон бусад аж ахуй нэгжүүд нэгдэн 221.1 сая ширхэг буюу нийт 1.5 тэрбум ширхэг мод тарихаар амлалт өгөөд ажил хэрэг болгоод ажиллаад эхлээд явж байна.

Тарьсан модны тоо төлөвлөгөөг та бүхэндээ танилцуулахад 2021 онд

аймаг, нийслэлийн хэмжээнд 2.6 сая ширхэг мод, 2022 онд амлалт авсан аймаг, нийслэлийн хэмжээнд 12.1 сая ширхэг мод, уул уурхайн аж ахуй нэгжүүд 2 сая ширхэг буюу нийтдээ 17.6 сая ширхэг мод тарьж ургуулсан тооцоо байна.

2023 онд аймаг, нийслэлийн хэмжээнд 33.9 сая ширхэг мод, уул уурхайн аж ахуй нэгжүүд 9 сая ширхэг мод буюу улсын хэмжээнд 42.9 сая ширхэг мод тарихаар урьдчилсан төлөвлөгөөг бид гаргаад байна.

Тарьц суулгацын нөөцийн хувьд улсын хэмжээнд нийтдээ 1750 га газар бүхий 336 ширхэг мод үржүүлгийн газар ажиллаж байна. 1 мод үржүүлгийн газар газрын дундаж талбайн хэмжээ 5.2 га орчим бөгөөд дээрх мод үржүүлгийн газрууд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 51.6 сая ширхэг тарьц, суулгац ургуулж байгаагаас 36.9 сая ширхэг нь тарьц, 14.6 сая ширхэг нь бол суулгац байгаа.

Үрийн нөөцийн хувьд улсын хэмжээнд 2023 оны байдлаар ойн үрийн нөөцийн санд нийтдээ 12.1 тонн үр бүрдүүлснээс шилмүүст төрлийн модны үр 2.3 тонн, навчит төрлийн модны үр 9.8 тонн байна.

Хүний нөөцийн хувьд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчлан ургуулах чиглэлээр 1017 багш, сургагчийг бэлтгэж, МУИС-д хоёрдогч бакалаврын зэрэг олгох ойн аж ахуйн хөтөлбөрийг шинээр нээж, 2022-2023 оны хичээж хичээлийн жилд нийтдээ 52 оюутай элсэн суралцаж байгаа.

Хөдөө аж ахуйн их сургууль, Батлан хамгаалах яамтай хамтран давхардсан тоогоор 23600 хүнд мод тарьж ургуулах 40 цагийн сургалт, 120 хүнд сургагч багшийн сургалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 54 хүнд сертификаттай, 51 хүнд сургагч багшийн сертификаттай сургалт, Хан-

Уул дүүргийн 51 хүнд сертификаттай сургалт. Нийт 23876 хүнд сургалтыг цахим танхим, практик хослуулан явуулсан.

Цаашид ойн салбарт ойрын 3 жил 7000 гаруй мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зайлшгүй шаардлага үүсээд байгаа.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай хамтран хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох төслийн санхүүжилтээр баруун 5 аймгийн 7 ойн ангийг анжис, модны нүх ухагч бүхий тракторын иж бүрдлээр хангах ажлыг зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 21 сум, дундын ойн анги тус бүрд 748 сая төгрөгөөр анжис, модны нүх ухагч бүхий 21 тракторын иж бүрдэл 347 сая төгрөгөөр 120 метр квадрат бүх талбайтай дуслын болон мананцар усалгааны систем бүхий 21 ширхэг хүлэмжийг нийлүүлээд байна.

Хяналт мониторингийн ажлууд зайлшгүй хийгдэх шаардлагатай байдаг. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, хяналт мониторинг талуудын оролцоог хангах хүрээнд terbutmod.mn цахим хуудас, ухаалаг утасны аппликэйшн шинээр хөгжүүлсэн. Энэхүү платформуор дамжуулан тарьсан мод, таригдах модны тооллого бүртгэл, мод үржүүлгийн газруудын байршил, тарьц суулгацын нөөц, үнэ хани, мэргэжлийн байгууллагуудын хүчин чадал, мод тарих сонирхол бүхий иргэд, аж ахуй нэгж болон санхүүжүүлэгч байгууллагуудын бүртгэл зэрэг мэдээлэлтэй танилцах бүрэн боломжтой болсон. Тус платформыг ашиглан тарьсан модыг бүртгэх оролцогч аж ахуй нэгж байгууллагад төсөл, хөтөлбөрийн талаар шаардлагатай мэдээллийг оруулах сургалт 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр цахимаар ойн мэдээллийн сан

хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх ойжуулалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээг нийтдээ 1048 га газар талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа. Үүнд ойжуулалт 128 га, ойн зурвас 80 га, байгалийн сэргэн ургалтад туслах 800 га, говь хээрийн бүсийг ойжуулахаар 25 га, уст цэг, баянбүрд хамгаалах, нөхөн сэргээх 15 га газраар бид нар төлөвлөж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын санаачилгаар аймаг бүрийн угтах үдэх хаалганы хажууд 10 га буюу түүнээс дээш талбайд ойн зурвас байгуулах талбайг шийдвэрлэж, Ойн газарт хүлээлгэж өгөхийг аймгийн Засаг дарга нарын Тамгын газарт мэдэгдсэн бөгөөд тус арга хэмжээг Ойн газар хариуцсан ажиллаж байна. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлууд хуралдаж эхнээсээ энэхүү асуудлуудыг шийдвэрлэж эхлээд байна.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан холбогдох яамдаас санал авахаар бэлтгээд байна. Энэхүү хууль дагалдах хуулиар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгаад байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа. Одоо Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мэдээллийг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар Ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Төмөртөмөө танилцуулна. 3 Номерын микрофоныг өгье.

З.Төмөртөмөө: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе.

Нийслэлийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний төлөвлөлт, хэрэгжилтийн байдлыг та бүхэндээ товч танилцуулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээг 2021 оны 11 дүгээр сард байгуулж нийслэлд 2030 он хүртэлх хугацаанд 120 саяас доошгүй мод тарьж, ургуулах амлалт өгсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд нийслэлийн зүгээс оруулах бодит хувь нэмрийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг нийслэлд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулаад байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-20 50”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг Нийслэлийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримтыг уялдуулан доройтсон ойг нөхөн сэргээх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр төлөвлөж 120 сая мод тарьж, арчлан хамгаалж, ургуулах үйл ажиллагааг Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт энэхүү ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх юм.

Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцын төсөлд хот байгуулалтын өнөөгийн нөхцөл байда, нийгэмд эдийн засгийн өсөлт, цаг үеийн өөрчлөлтүүд, ирээдүйн хотжилтын чиг хандлагад тулгуурлан Улаанбаатар хотыг тогтвортой, компакт хүртээмжтэй,

хэмнэлтэй, дасан зохицох идэвхтэй хот болох 6 зорилтыг тодорхойлж, амьдралын таатай орчныг бүрдүүлсэн хот болгон хөгжүүлэх алсын харааг дэвшүүлж байгаа.

Улаанбаатар хотыг 2040 оны түвшинд суурьшил, үйлдвэр, ногоон байгууламж, тусгай бүс гэсэн хот байгуулалтын үндсэн бүтэцтэй төвлөрсөн болон хэсэгчилсэн хангамжтай олон төвт хот болгон хөгжүүлэх зорилттой.

Энэхүү хөгжлийн төлөвлөлтийн бичиг баримт, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Парисын хэлэлцээрт Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу Улаанбаатар хотын хувь нэмрийг тодорхойлж, ногоон дэд бүтцийн хувьд Нийслэлийн ойн санг төлөвлөлтийн 9 массивт хуваан хамгаалж, ойгоор бүрхэгдсэн талбай, 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөсөн.

Энэ нь Нийслэлд 2030 он гэхэд 120 сая мод ургуулж, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөртэй уялдаж, тусгагдсан ажил байгаа юм. Нийслэл Улаанбаатар хот нийт 470444 га нутаг дэвсгэртэй бөгөөд 4-ний 1 хувийг буюу 116258 га талбайг ойн сан газар эзэлдэг. Ойн сангийн талбайн 95233 га буюу 84.4 хувийг ойгоор бүрхэгдсэн, 17543 га буюу 15.6 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байгаа юм.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн 17098 га нь ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай талбай байгаа. “Тэрбум мод” хөтөлбөрийн үр дүнд 2030 он гэхэд нийслэлийн нутаг дэвсгэрийг ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 20.2 хувь байсныг 22.9 хувьд хүргэхээр зорилт 50 ажиллаж байгаа юм.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг нийслэлд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд 2030 он хүртэлх

хугацаанд нийслэлийн нутаг дэвсгэрийг ойжуулах, ойн нөхөн сэргээлтийг 12948 га талбайд 20.7 сая ширхэг бүх төрлийн хамгаалалтын ойн зурвас, 3500 га талбайд 34.3 сая ширхэг, Улаанбаатар хотын ногоон байгууламж үзэжүүлэхийг нэмэгдүүлэх чиглэлээр 3750 га талбайд 65 сая ширхэг нийт 120 сая ширхэг мод тарьж, арчлан хамгаалж ургуулахаар төлөвлөсөн байгаа юм.

Нийслэлийн хэмжээнд 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 29 аж ахуй нэгжийн нийт 49.6 га талбайд мод үржүүлгийн газар байна. Эдгээрт 4.6 сая ширхэг тарьц, суулгацын нөөцтэй гэсэн урьдчилсан мэдээг ирүүлээд байна.

Зорилт 1-ийн хүрээнд Улаанбаатар хотын ойн сангийн хомсдол доройтлыг бууруулах, түймэрт өртсөн хөнөөлт шавжид нэрвэгдсэн мод бэлтгэсэн талбайг ойжуулах, нөхөн сэргээх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 20.2 хувь байсныг 23 хувьд хүргэх. Нийслэлийн хэмжээнд 2030 он гэхэд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг 12948 га талбайд хийж гүйцэтгэнэ. 2023 онд 42 га га талбайд 105000 ширхэг шилмүүст модны тарьцаар ойжуулалтыг бид бүхэн хийнэ.

Зорилт 2-ын хүрээнд цөлжилттэй тэмцэх, хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах хүнсний хангамжийг сайжруулах хүрээнд авто зам, төмөр зам, уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хот, суурин газруудад хамгаалалтын ойн зурвас байгуулах, тохиромжтой газар газруудад уст цэг, хөв байгуулах замаар жимс жимсгэнэ, ашигт малтмал, ашигт ургамал тариалж агро ойн аж ахуйг хөгжүүлнэ гэсэн ийм зорилттой.

Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 3350 га талбайд хийж, 34.3 сая мод тарих зорилго дэвшүүлсэн.

2023 онд 4.4 га талбайд 3.9 мянган ширхэг навчит модны суулгац, 30 га талбайд жимс жимсгэнэ тарьж ургуулахаар төлөвлөн ажлууд явж байна.

Зорилт 3-ын хүрээнд Нийслэлийн иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлж, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хотын иргэний аюулгүй байдлыг хангах зорилгоор 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 3750 га цэцэрлэгжүүлэлт, нийт 65 сая ширхэг мод, бут, сөөг тарих ийм төлөвлөгөөтэй байгаа юм.

Жишээлбэл Баянзүрх дүүрэгт 7.9 сая, Сүхбаатар дүүрэгт 7 сая, Чингэлтэй дүүрэгт 7 сая, Хан-Уул дүүрэг 7.2, Баянгол дүүрэгт 7, Сонгинохайрхан дүүрэгт 7.9, Налайх дүүрэг 7, Багануур дүүрэг 7, Багахангай дүүрэгт 7 сая тус тус таригдана гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Хэрэгжилтийг хот, дүүргийн түвшинд зохион байгуулах чиг үүргийг бүх шатын Засаг дарга нар хариуцна. Зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд 2030 он гэхэд Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 28245 ширхэг, хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжид 25216, тусгай хэрэгцээний ногоон байгууламжид 11613 тус тус таригдана гэсэн ийм төлөвлөгөөг гаргасан байгаа юм.

Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, Хотын ногоон байгууламж, Цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 2021 оны түвшинд 5.1 хувьтай байна. 2030 он гэхэд бол өндөр зорилт тавьж, 25 хувьд хүрнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд хотын орон зайн төлөвлөлтөд хотын баруун хэсэгт хотыг дахин төлөвлөж, одоо байгаа гэр хорооллыг хашаа бүр 5-аас доошгүй мод тарьж ургуулан хөрөнгийн үнэлгээнд тооцуулах механизмыг бүрдүүлж, ногоон коридор, ногоон бүс болгохоор тусгасан байдаг юм.

Нийслэлийн ногоон бүсийн ойг нөхөн сэргээх, хамгаалалтын ойн зурвас байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд 86.6 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалахад 8.2 их наяд төгрөгийн улсын төсөв, хөрөнгийг шаардагдах урьдчилсан тооцоо хийгдээд байгаа юм.

Энэхүү арга хэмжээг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр бид бүхэн төлөвлөөд байна.

Түүнчлэн иргэдийн санаачилга, оролцоог нэмэгдүүлж иргэд, аж ахуй нэгжийг зохион байгуулж, тусламж, хандив авах, ногоон сан бий болгох ойжуулалтыг дэмжсэн олон улсын хөрөнгө оруулалт шинээр татах замаар энэхүү төслүүд хэрэгжих учиртай.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Нийслэлд хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний хүрээнд нэн тэргүүнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр бид бүхэн зорьж байна.

Стандартыг хангасан тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бодлого эрх зүйн орчныг сайжруулах

Стандарт тавигдах шаардлагыг хэрэгжилтийг хангуулах, мод үржүүлгийн газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, автоматжуулсан мод

үржүүлгийн газруудыг шинээр бий болгох.

Ойн мэргэжлийн байгууллагууд мод үржүүлгийн зориулалтаар газар олгож, дэмжлэг үзүүлэх. Улаанбаатар хотын зүгээс.

Мод үржүүлдэг аж ахуй нэгжүүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, татварын чөлөөлөлт.

Мод үржүүлэг, агро ойн аж ахуй байгуулахад усан хангамж, ус ашиглалтыг зохицуулалт хийх.

Агро ойн аж ахуйн загварыг олон улсын туршилагад үндэслэл бий болгон хөгжүүлэх.

Иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог сайжруулах.

Мод тарих соёлыг нутагшуулах нөлөөллийн аяныг их хэмжээгээр зохион байгуулах.

Нийгмийн хариуцлагын хүрээнд мод тарих үйл ажиллагааг улам идэвхжүүлэх.

Мод тарьсан айл, өрхийг урамшуулдаг болох.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийслэлийн мод үржүүлгийн газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх. Энэ чиглэлийн аж ахуй нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод үржүүлгийн чиглэлээр олгох боломжтой газруудын байршлыг тогтоон судалж, олон нийтэд танилцуулах гэсэн. Ийм ажлын төлөвлөгөө байна.

Б.Саранчимэг: Төмөртөмөө даргад баярлалаа. Тэгэхээр мэдээлэлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Юуны өмнө бас ажлын хэсгийг танилцуулчихъя. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ, Ойн газрын дарга Оюунсанаа, мөн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамнаас Ариунням Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын шинжээч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Төмөртөмөө Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Эрдэнэсайхан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбат Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Энхтайван Нийслэлийн Байгаль орчны газрын дарга, Тэмүүжин мөн газрын Ойн хэлтсийн дарга ирсэн байна.

Гишүүд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Өгчихсөн байна уу? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүнийг асуултаа асуухыг урьж байна.

Г.Дамдинням: “Тэрбум мод”-ны мэдээллийг сонслоо. Тэгээд мод тарихыг бол хийгээд байгаа юм. Сүүлийн жилүүдэд бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хийж байгаа ажил бол нэлээн эрчимтэй сайн явж байгаа юм. Харин Нийслэлийн бүс нутагт байгаа энэ моддоо энэ ногоон байгууламжаа хэрхэн хамгаалж байгаа вэ гэдэг асуудал яригдана. Ялангуяа би өмнөх Байнгын хорооны хурлаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнээс энэ олон түмний дунд авлигал хороолол гэж нэрлэгдээд энэ Туул голын энэ усны ай сав газар баригдаад ингээд үндсэндээ дуусаж байгаа. Энэ усан парк нэрээр аваад Улаанбаатар хотоос

газрыг аваад ингээд Байгаль орчны яам, Засгийн газрын гишүүн нь хууль зөрччихсөн гэж мэдэгдээд байхад албан бичгээр илэрхийлээд байхад яваад байгаа энэ барилгыг Улаанбаатар хотын захиргаанаас асуумаар байгаа юм. Төмөртөмөө дарга энэ дээр яагаад энэ барилга яваад байгаа юм? Яг энэ барилгатай холбоотой 2 газрын 2 том дарга энд сууж байна шүү дээ. Байгаль орчны сайд сууж байна, Улаанбаатар хотын даргын орлогч сууж байна. Яг энэ асуудлыг хариуцсан.

Энэ барилга яагаад яваад байгаа юм? Яагаад би энийг асуугаад байгаа вэ гэвэл би түрүүн хэллээ шүү дээ. Байгаа мод, бут, сөөгийг нь хядаж байгаад усны эх ундарга дээр нь барилга бариад байна. Одоо Энхтайваны гүүрнээс зүүн чиглэлд баригдаж байгаа энэ хотхоныг харсан хүмүүс, энэ барилгыг харсан хүмүүс дээд талд нь бүгдэнг нь та нар бас газрыг нь олгочихсон л байгаа байх. Тэгээд энэ хотхонууд үргэлжлээд барилгын ажил нь явна. Энэ барьж байгаа юм чинь би барина гээд л явна.

Улаанбаатар хот усгүй болж байгаа. Олон улсын олон судалгааны байгууллагуудаас усны хомсдолд орж байгаа гэдэг мэдээллийг бол ил нийтэд тавиад эхэлчихсэн юм шүү дээ. Мянганы сорилтын сангаар усны хангамжийг нь хийгээд л, хийх гээд л одоо ажиллаж байх шиг байна.

Тэгэхээр энэ дээр Улаанбаатар хотын орлогч дарга Төмөртөмөө та дарга хариу өгнө Байнгын хороонд, энэ дээр шууд би асууж байна. Хэн зөвшөөрөл өгчихсөн юм? Ямар хууль зөрччихсөн юм? Яагаад энэ яваад байгаа юм энэ дээр хариулт асууж байна.

Хоёрдугаар асуулт бол Бат-Эрдэнэ сайдаас асууя. Энэ “Тэрбум мод”-ны хөтөлбөр маань ямар менежментээр, олон улсын менежмент зөвлөх үйлчилгээ ер нь авч явж байгаа юу? Ургуулсан моддоо бүртгээж байгаа юу? Олон улсын CO₂-ыг бууруулах,

тэрийг зарах, солих энэ үйлдвэржчихсэн орнуудын энэ carbon tax гэж ярьдаг юм даа. Энэ дээр ер нь ажиллах ажилбар хийгдэж байгаа юу? Энэ асуултад хариулаач. Ийм 2 асуулт байна. Тэгээд тодруулна.

Б.Саранчимэг: Эхлээд Төмөртөмөө даргаа хариулъя. 3 номерын микрофон.

3.Төмөртөмөө: Дамдинням гишүүний асуултад би хариулъя. Яг дэд бүтцийн асуудал хариуцдаг хүмүүс, орлогч дарга маань бол их тодорхой хариулах байсан. Миний хувьд нийгмийн салбар, ногоон байгууламж, агаар орчны бохирдол хариуцдаг.

Миний хамгийн сүүлд хэлж чадах мэдээлэл бол нэгдүгээрт энэ газар төмөр замын зурвас бүхий газар. Төмөр замтай зайлшгүй зөвшилцсөн байх ёстой байдаг. Төмөр замын 1941 оны байгуулсан гэрээгээр санагдаж байна. 49 он билүү.

Хоёрдугаарт нь бол энэ хот байгуулалтын төлөвлөгөө зураг батлах үйл явц бол Улаанбаатар хотын энэ Хот байгуулалт, төлөвлөлтийн газар дээр хийгддэг. Өнөөдрийн байдлаар бол Улаанбаатар хотоос энэ олон нийтийн нэршилээр хэлээд байгаа энэ авлига хорооллыг бол удаа дараа зогсоох үйл ажиллагааг нь зөвшөөрөлгүй байна гэсэн мэдэгдлүүдийг өгч байсан. Хамгийн сүүлд бол Захиргааны хэргийн шүүх дээр энэ тухайн компанийнх нь талд гарчихсан ингээд яваад байгаа юм байна лээ.

Ер нь бол Улаанбаатар хотын зүгээс тодорхой асуудал дээр газар цуцлах дээр хүртэл энэ “Ривер Гарден”-ны баруун талын “Хан Хилс” орчмын бүс бүгдийг нь Улаанбаатар хотын дарга цуцалсан. Ажил аваад. Тэгээд л буцаад л шүүхийн шийдвэр дээр, Захиргааны хэргийн шүүх дээр энэ шийдвэрүүд унадаг. Тэгээд л буцаагаад шүүхээс мэдэгдэл ирдэг. Энэ компанийн талд байна гэсэн ийм л байдалтай асуудлууд л яваад байдаг юм байна лээ.

Одоогийн байдлаар хот дэмжээд энэ компанийн үйл ажиллагааг явуулаад байгаа юм ерөөсөө байхгүй. Тэх, үүхийн шийдвэр биелүүлнэ л гэсэн үг.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд хариулъя. 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Дамдинням гишүүний асуултад хариулъя. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бид нар ялангуяа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол зөвхөн мод тарьж ургуулах асуудал биш. Энэ бол эдийн засгийн эргэлтийг дэмжих буюу carbon маркеттай холбоо бүхий эдийн засгийн цар хүрээгээрээ маш том, ялангуяа өнөөдөр Уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-ын конвенцын талуудын Бага хурал, Цөлжилтийн эсрэг конвенцын талуудын Бага хурал гээд маш олон суурь конвенцын бага хурал дээр талуудын бага хурал дээр яригддаг маш том сэдэв. Carbon маркеттай холбоо бүхий асуудал дээр зарим засгийн газрууд хүртэл өөрсдийнхөө өрийг хөнгөлөх, тодорхой хэмжээнд арилжаанд оруулах ийм том систем явж байгаа. Манай хувьд бол эхлүүлсэн явж байгаа. Модон дээр би ярьж байгаа шүү. Эхлүүлсэн явж байгаа. “Трафигура” компанитай бид нар хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.

Ер нь бол мод гэдэг маань манай нөгөө газар зүйн байрлалаасаа шалтгаалаад хаана, ямар мод, ямар хөрсөнд гэдэг ийм тусдаа тусдаа ТЭЗҮ-нүүд хийгдэж байгаа юм. Тэгэхээр мод болгон өөрөө хүлэмжийн ялгарлыг хэдий хэмжээний шингээлт явагдах вэ гэдэг мод бүр дээрээ өөр өөр байгаа. Тэр утгаараа бол ТЭЗҮ нь тусдаа тусдаа байгуулагдах.

Олон улсын байгууллагуудын түвшинд бол бид нар Дэлхийн банк, UNDF гээд олон улсын байгууллагууд бол бүгд анхаарлаа тавиад энэ дээр бүгд ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам *terbitmod.mn* гээд энэ сайтаар дамжуулаад бүртгэлийг албан ёсоор бас явуулж байгаа. Энэ дээр бол бид нар тодорхой хэмжээний мод үржүүлгийн компаниудын тусгай зөвшөөрөлтэй компаниудын мэдээллүүдийг оруулахаасаа гадна заавал тарьж ургуулсан моднуудаа бол бүртгүүлэх *1 систем*.

Нөгөөдөх нь мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн холбоотой *ICT* групптэй хамтраад биржийн арилжааг бид нар эхлүүлсэн байгаа юм. *Modlog.mn* Тухайлах юм бол тухайн арилжаа маань Монгол Улсын аль *1* аймгаас байдаг юм уу, сумаас байдаг юм уу мод үржүүлгийн компани бид нар энэ модыг худалдмаар байна гэвэл *modlog.mn* дээр шууд оруулаад тэрийг хаанаас ч хамаагүй шууд худалдан авах үнээ тавиад ингээд биржийн арилжааг бол яг эхлүүлээд явж байгаа. Тэгэхээр энэ бол цаашидаа амжилттай явах ёстой болов уу гэж бодож байна.

Хүлэмжийн ялгарлыг бууруулахтай холбоо бүхий асуудал дээр бид нар ялангуяа Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон улстай бол хамтын ажиллагааны санамж бичгийг Байгаль орчны яамнуудтай 2022 ондоо багтааж бид нар бүгдийг нь хийсэн.

2023 онд бид нар Сингапур Улстай дөнгөж саяхан 2 дугаар сард хийлээ. Австрали улстай бид нар хийхээр ажиллаж байна. Австрали улс Сингапур улстай хийгдэж байгаа *1* онцлог байгаа юм. Хүлэмжийн ялгарлыг бид нар тооцоолох ёстой. Тооллого арга зүйгээр хангах ёстой. Тэгэхээр сансрын буюу нөгөө сансраас бид нар хүлэмжийн ялгарал, шингээлтийг бид нар бүгд тооцох систем дээр тухайн Сингапур болон Австрали 2 улстай хамтарч ажиллахаар санамж бичгийг байгуулаад Австралитай бид нар байгуулахаар ажиллаж байгаа. Сингапуртай бид нар байгуулчихсан ажиллаж байгаа.

Үүн дээрээс гарсан сансрын тооллогоос улбаалаад бид нар тодорхой хэмжээнд доод түвшинд буюу бид нар тэр “Трафигура” болон бусад компаниудтай хийгдэж байгаа ажил үүдийг хийж явах. Блокчэинтэй холбоотой асуудлууд энэ дээр мөн орж ирж хөндөгдөж байгаа. Тухайлах юм бол блокчэинээр тарьсан мод болгонд тодорхой хэмжээний санхүүжилт олгох. Ургуулах хэмжээгээр, ургалтын хэмжээгээр тодорхой хэмжээний төлбөрийн хэмжээ ихсэх. Энэ нь өөрөө хүлэмжийн ялгарал дээр хэдий хэмжээний хүлэмжийн ялгарлыг бууруулж байгаа вэ гэдэг энэ тооцоолол.

Үндэсний тодорхойлсон хувь нэмэр дээр бол бид нар 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулах ийм тооцоолууд явж байгаа. Арилжааны 2 систем. 1 нь бол 22.7 хувиар бууруулах нь бид нар олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн манай үүрэг учраас бид нар энийг заавал хийх ёстой.

Нөгөө талд нь арилжааны системээ бид нар яаж хийх вэ тухайлбал. Энэ дээр ямар арилжааг явуулах вэ тэр нь өөрөө 22 оны 7-доо орохгүй байх ёстой гэдэг зарчмыг олон улсын байгууллагууд тавьж байгаа юм. Тэгээд энэ дээр бол бид нарт тодорхой хэмжээний газар нутгийнхаа хэмжээгээр байр зүйгээсээ шалтгаалаад тодорхой ийм төслүүдийг хамтарч хэрэгжүүлэхээр ажлууд эхлээд явж байгаа.

Б.Саранчимэг: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Авлигал хороолол гэж нэрлэгддэг тэр хороолол дээр дахиад асуулт байна. Улаанбаатар хотоос газар авах, барилга барих, зориулалт өөрчлөхөд Улаанбаатар хотоос бүх гарын үсгийг цуглуулна. Байгаль орчны таны харьяанд байдаг жишээ нь хотын энэ Байгаль орчны газар дэмжиж санал өгсөн юм уу? Хэрвээ Байгаль орчны газар энийг дэмжиж санал өгөөгүй бол энэ барилга

эхлэхгүй байхгүй юу. Газрын зөвшөөрөл нь гарахгүй. Тэгэхээр өгчихсөн юм байна тийм үү? Тэгж ойлгож болох уу? Нэг.

Хоёрдугаарт энэ Байгаль орчны газраас Улаанбаатар хотын захиргаа ингээд Засгийн газартаа дийлддэггүй л ийм газар болчихсон байна гэж ойлгоход болох уу? Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайд зогсооё гээд бүх газарт өгөөд байдаг. Улаанбаатар хотын захиргаа зогсооё бид нар хууль бус байна гээд байдаг. Тэгэхэд энэ газар ингээд л өөрөөрөө барилгаа бариад яваад байна гэж ойлгож болох уу? Ингэж хариуллаа шүү дээ саяын хариултаас тийм? Тэгэхээр энэ дээр хариулаач сайд болон дарга нар.

Б.Саранчимэг: Эхлээд Бат-Эрдэнэ сайд хариулъя. 2 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Одоо тийм л болчихоод байгаа юм. Бодит үнэн нь яг л ийм байна. Тэгээд худлаа хэлэлтэй биш ямар. Зөвхөн энэ асуудал биш. Зөвхөн энэ асуудал биш. Одоо тэр “Хан Хилс”-ийн хажууд баригдаж байгаа орон сууцтай холбоотой асуудал байна. “Ривер Гарден”, “Хан Хилс”-ийн зэргэлдээ түвшинд баригдаж байгаа асуудлууд мөн адилхан асуудал. Энэ бол манай Усны газраас Усны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчихсөн гээд тогтоолууд нь гарчихсан, дүгнэлтүүд нь гарчихсан.

Тухайлах юм бол усны онцгой хамгаалалтын бүс 50 метр. Гэтэл 2016 оны 4 сарын 5-ны өдөр Нийслэлийн иргэдийн төлөөлөгч нарын хурлаар онцгой хамгаалалтын бүсийн заагийг нь авч байгаад, болиулж байгаад зөвшөөрөл олгочихсон байгаа юм. Тэгээд энэ Усны тухай хууль мөрдөгдөхгүй байна. Ойн тухай хууль мөрдөгдөхгүй байна. Энэ бол Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дээр 2016 оны 4 сарын 5-ы өдөр.../минут дуусав./

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд 1 минут нэмж өгье. 2 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Монгол Улс уул нь Ойн хууль, Усны хууль нэг л хуультай. Нийслэлийн ойн хууль, Аймгийн ойн хууль, Аймгийн Усны хууль, Нийслэлийн Усны хууль гэдэг хууль тогтоомж байхгүй. Тэгэхээр бид нар энэ дээр бол хуулиа мөрдөж ажиллаач гэдгийг Нийслэлийн энэ Байгаль орчны газарт бол хандаж байгаа. Нийслэлийн Засаг даргад хандаж байгаа. Одоо би өнгөрсөн удаа, маш олон удаа асуусан. Одоо ч би дахиад хэлэхэд 2022 оны 4 сарын 25-ны өдөр авлига хороололтой холбоотой газрыг зогсоох бичгийг Нийслэлд явуулсан. Өнөөдрийг хүртэл хариу нь ирээгүй байгаа.

Өнөөдөр 4 сарын 18-ны өдөр 23 оны. Өөрөөр хэлбэл 1 жилийн хугацаа болж байна гэсэн үг. Нөгөө талдаа 30 хоногийн хугацаанд хариу өгөх ёстой хуулийн заалттай. 365 хоног болж байна л гэсэн үг.

Б.Саранчимэг: 3 номерын микрофоныг өгье.

З.Төмөртөмөө: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл, тайлбар авлаа хариулъя. Энэ газартай холбоотой асуудал бол 1, 2 жилийн дотор гарч ирчхээд байгаа асуудал бас биш байгаа байх. Анх 2008 оны 9 сарын 17-нд орон сууцын зориулалтаар тухайн газар олгогдож байсанг. Газар эзэмших эрхийг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн захирамжаар цуцалсан байгаа юм. 2020 онд.

Гэвч Захиргааны хэргийн шүүхийн 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрээр Нийслэлийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгож, газрын эрхийг сэргээх шийдвэр гарсан. Тэгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй учраас 2022 оны 1 дүгээр сарын 11-ний захирамжаар тухайн газарт худалдаа, нийтийн үйлчилгээ, төв цогцолбор, орон сууц, сургууль, цэцэрлэгийн

зориулалттайгаар эзэмшүүлэх захирамжийг сэргээсэн гэсэн ийм мэдээлэл байна. Сая Хот байгуулалтын газраас авлаа.

Манай Байгаль орчны газраас тухайн олгогдсон газар зориулалтыг нь өөрчлөх энэ усан паркийг орон сууцын барилга болгоход дэмжсэн бичиг огт өгөөгүй юм байна. Бид нартай зөвлөлдөөгүй гэсэн үг.

Б.Саранчимэг: Дамдинням гишүүнд дахиад асуух боломж өгье.

Г.Дамдинням: Үгүй одоо энэ дээр нэг юм ерөөсөө ойлгохгүй юм. Байгаль орчны газраас дэмжсэн бичиг өгөөгүй бол энэ газрын захирамж гарахгүй байхгүй юу. Хууль зөрчөөд байна шүү дээ. хууль зөрчсөн байна тээ?

Хоёрдугаарт Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шийдвэрийг л манай Улаанбаатар хотын захиргаа айхтар биелүүлээд яваад байгаа дуулдаад байгаа юм даа. Яагаад давж заалдаагүй юм бол? Энэ дээр хариулт байна уу та нарт. Энэ хотын энэ Байгаль орчны газрынхан очоод тэр үйл ажиллагааг нь зогсоож болдоггүй юм уу? Та нар эрхтэй шүү дээ. Мэргэжлийн ерөнхий газар тараад Улаанбаатар хотод энэ хяналтын байгууллагууд нь бүгдээрээ оччихсон байгаа шүү дээ. Та Улаанбаатар хотын орлогч дарга хүн байна. Мэргэжлийн хяналт тэр Барилга, хот байгуулалтын газрынхаа хүмүүсийг явуулаад энийг зогсоох эрхтэй шүү дээ. Ингээд бид нар ийм юмаа хийхгүй байж байж “Тэрбум мод” гээд хотыг ногооруулна гээд яриад сууж байгаа чинь тийм зөв сонсогдохгүй байна шүү дээ хүмүүс ээ.

Яагаад зогсоохгүй байгаа юм та нар энийг? Чадахгүй байгаа бол тэр цагдаагаа явуулаад зогсоогооч.

Б.Саранчимэг: Төмөртөмөө дарга нэмж хариулъя.

3.Төмөртөмөө: Гишүүнтэй бол санал нэг байна. Бид нарын хувьд бол бас тодорхой өөрсдийн эрх хэмжээ гэж байна. Шууд зогсоох бид нарт эрх мэдэл үнэхээр алга байна. Тэх энэ шүүх дээр очоод л бүх асуудал унаж байна гэж түрүүн танд тодорхой хэллээ. Ер нь ганцхан энэ биш олон газартай холбоотой ийм л асуудлууд байгаа юм. Хотын дарга нэг захирамж гаргаад л цуцалдаг, эргээд л нөгөө эрх мөнгө, эрх мэдэл, мөнгө төгрөгтэй компаниуд нь шүүх дээр очоод л ялчихдаг. Энэ тогтолцоогоо л нэгдүгээрт нь эргэж хармаар байгаа юм.

Тэгэхгүй бол энэ хувийн хэвшилүүдийн хийж байгаа бүтээн байгуулалтуудыг хаасан, боосон, хааж байна гэдэг ийм шүүмж бол маш их явж байгаа шүү дээ. Энэ мэтчилэн асуудал дээр бол шууд зогсоох эрх мэдэл бид нарт алга байна.

Байгаль орчны газрын ажил албан тушаалтнууд маань одоо бол 1 харьцангуй эрх хэмжээ нэмэгдэж байна. Яг таны хэлж байгаагаар мэргэжлийн хяналтын чиг үүрэг ирсэн. Эд нар очихвол тодорхой актуудыг тавих боломжтой. Эргээд таны хэлснээр.../минут дуусав./

Б.Саранчимэг: Баярлалаа. Болорчулуун гишүүн асуултаа асууя.

Х.Болорчулуун: “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ажлын явцын талаар ярьж байна Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Манай улсын газар нутгийн 7-хон хувь нь ойтой үнэхээр бага л даа. Дэлхий дээр ер нь хамгийн бага ой модтой улсуудын тоонд л бас орно.

Тэгэхээр цөлжилттэй тэмцэх уур амьсгалын микро орчин, зөөлөн орчин бүрдүүлэхэд моджуулах, ойжуулах юу юунаас чухал байдгийг бүгд мэдэж байгаа.

Тийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх “Тэрбум мод” хөдөлгөөнийг санаачилсан. Энийг бид нар зүгээр шоу болгочихгүй жинхэнэ ажил хэрэг болгох хэрэгтэй байна. “Тэрбум мод” тарих нэг өөр шүү. Тарих нэг хэрэг. Арчлах, ургуулах гэдэг чинь бол хамгийн чухал ажил. Энэ дээрээ их анхааралтай ургуулсан модны тоогоор л тэр модны тоог бүртгэлийг хэмжихээс биш тарьснаараа хэмжиж болохгүй л дээ. Тарьсан модоо бүртгэж байгаа гэж ярьж байна.

Тэгэхээр одоо энэ мод тарих нь гэхэд хаана тарих вэ? Зүгээр нэг газрууд тарихаар усгүй газар ургахгүй. Хот суурин газраа мэдээж тарина. Түүнээс гадна газар тариалангийн талбай тойруулаад мод тарих нь юу юунаас чухал. Тэгвэл тэр энэ мод тарих баахан компаниуд жагсаасан байна. Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгойгоос авхуулаад Оюутолгой гээд ингээд л. Энэ компаниудыг тэр газар тариалангийн талбай тойруулаад газрыг нь компаниуд өгье гэж байгаа шүү дээ. Мод тарих газрыг нь. Хашааг нь барьчих, модоо тарьчих.

Харин арчлах, ургуулахыг нь бол энэ тариаланчид хариуцъя. Энэ бол 2 талдаа үйлчлээд их зүгээр юм. Тэрнээс биш яг газар тариаланчид ашиг багатай, алдагдалтай хашаагаа ч бүрэн хамгаалж чадахгүй байгаа байхгүй юу. Газар тариалангийн хашаа барьж.

Ер нь тэгээд энэ газар тариалангийн зөвхөн компанид үйлчилж байгаа биш хөрсөө Үндсэн хуульд газар бол ард түмний өмч байгаа юм. Тэр хөрсөө хамгаалж байгаа хэрэг л дээ. Хоёр талын ач холбогдолтой. Энэ дээр бол бас бүүр төлөвлөгөөтэй ажил зохион байгуулмаар байна. Манай яамтай хамтраад гэдгийг бас хэлье.

Түүнээс гадна энэ энэ Дорнодын Эрээний давааг ойжуулах төсөл гээд явагдаж байсан. яригдаж байсан. 1 сая доллароор билүү? Тэр одоо сүүлийн үед

чимээгүй болчихлоо яасан бэ гэж бас асууя. Энэ явагдах уу цаашидаа энэ төсөл? Дорнодын Эрээнд бол маш их модтой байсан. Ойн түймэр шатсан. Ингээд ойжуулах, моджуулах ажил яригдаж байсан, явагдаж байсан. Тэгээд сүүлийн үед чимээгүй болчихлоо энэ талаар асууя.

Гуравдугаарт сая Дамдинням гишүүн асуулаа. Энэ зөвшөөрөлгүй барилга бариад, ингээд барьчихдаг ингээд Нийслэл сая Төмөртөмөө дарга хэлж байна л даа Нийслэл Захиргааны хэргийн шүүх дээр ялагдлаа гэж байна. Та нар тэгээд давж заалдаг юм уу? Дээд шүүх хүртэл нь явдаг юм уу? Тэр буруу гаргасан гэж үзэж байгаа бол Сахилгын хороон дээр шүүгчийг нь өгдөг юм уу? Өгөх ёстой байхгүй юу. Тэгж л ажиллахаас биш зүгээр ялагдсан гээд яг үнэндээ бол Нийслэлийнхэн хуйвалддаг байхгүй юу. Хуурамчаар зориуд нөгөө бух унаж өгнө гэгчээр ялгадаг байхгүй юу. Ийм байдал яг амьдрал дээр байгаа шүү дээ. Хуйвалдаж өгчхөөд. Энэ байдал дээрээ засаж залруулж ажиллах хэрэгтэй шүү гэдгийг бас нэмж хэлье.

Б.Саранчимэг: 2 номерын микрофоныг өгье. Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Болорчулуун гишүүн, Болорчулуун сайдын асуултад хариулъя. “Тэрбум мод”-ны 200 орчим сая мод болон жимс жимсгэнийн мод байгаа. Энэ бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр бас хамтын ажиллагааны хүрээнд зайлиггүй явах ёстой ажил. Газар тариалангийн хашаатай холбоо бүхий асуудлууд байна. Манайхаас тооцоо судалгаа хийж үзсэн 20000 километр хашаа хэрэгтэй байгаа. Газар тариалангийн бүс дээр бид нар газар тариалан эрхлэгчтэй бас мөн уулзсан. Хашаагаа бариад өгчихвөл модоо бид нар тариад өөрсдөө ингээд хамгаалалтын байдлаар яг дагуулаад тарья гэдэг энэ асуудлыг хөндөж байгаа.

Тэгээд 20000 километр хашаа барих төсөв Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд байхгүй. Үүнтэй холбоотой тодорхой асуудлууд зогсчихоод байгаа юм. Жимс жимсгэнийн модтой холбоотой асуудал дээр бид нар жимс жимсгэнийн холбоотой хамтраад төслийг нь боловсруулсан. Төслийг бид нар Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад харилцааны яамтай нийтдээ 4 төслийг бид нар олон улсын санхүүжилт авахаар хөөцөлдөж байгаа. Үүний нэг нь бол жимс жимсгэнийн модтой холбоо бүхий асуудал буюу холбооноос нь оруулж ирсэн төслийг бид нар дэмжээд явж байгаа.

Дорнодын Баян-Уул сумын Эрээний нуруутай холбоотой асуудал. Энэ 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо хуралдсан дэлхийн ойн чуулган дээр бид нар өмнө нь материалаа явуулаад Азийн ойн хамтын ажиллагааны байгууллагаас манай төсөл шалгарсан. Сая долларын мод үржүүлгийн газар байгуулах тухай Эрээний нурууг нөхөн сэргээхтэй холбоо бүхий төслийг хэрэгжүүлэхээр шалгараад ингээд 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс тухайн төслийг нээгээд ингээд ажиллаад явж байгаа.

Энэ бол 1 сая ам долларын төсөл бол тэнд буцалтгүй байдлаар хэрэгжих. Энэ бол Дэлхийн ойн чуулганы үеэр бас Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын очиж манай Ойн агентлагийн, тухайн үеийн Ойн бодлого зохицуулалтын газрын хийсэн томоохон ажлуудын 1 нь бол энэ байгаа.

Хашаатай холбоотой асуудал дээр цаашидаа шийдлийг аль аль талдаа ярихгүй бол миний саяын хэлдэг 20000 километр хашаа татахтай холбоо бүхий асуудал бол төр энийг дангаараа хийх ямар ч боломжгүй. Хувийн хэвшилтэй хамтарсан байдлаар л хийхгүй бол болохгүй ийм асуудал зайлиггүй хөндөгдөж байгаа. Тэгэхээр бол хашаан дээр бол манайх дээр ямар ч шийдэл алга.

Төсөв байхгүй учраас. Бусад талаар бол жимс, жимсгэнийн мод болон бусад мод тарьж ургуулахтай холбоо бүхий асуудал дээр хяналтын ажлууд явагдаж байгаа.

Ялангуяа говийн бүсээр бол ургалт 88 хувьтай байгаа. 88-92 хувьтай байгаа. Бид нар байнгын хянаж байгаа. Тогтолцооны хувьд бид нар төр өөрөө мод тарихаас илүүтэй мод үржүүлгийн газруудтай өөрсөдтэй нь хамтраад, төсөв мөнгийг нь уул уурхайн компаниудаас гаргаж өгөөд мод үржүүлгийн компани өөрсдөө тэр модоо тариад хэрвээ тухайн мод үхэх юм бол мод үржүүлгийн газраасаа өөрсдөө дахиж модоо авчирч тарьж ургуулах энэ систем дээр бид нар явж байгаа.

Сэлэнгэ аймагт бол жишээлбэл мод ургалт бол 97-99 хувьтай байгаа. Тэгэхээр хяналтын ажлын хэсэг бид нар бол байгуулаад тарьсан мод болгоны араас 1 талдаа бүртгэл хийх, түрүүний хэлсэн *terbitmod.mn* дээр нөхөж бүртгэл хийх асуудлууд. Нөгөө талдаа модны ургалттай холбоо бүхий асуудлууд.

2023 онд бид нар суурьшлын бүсүүдээр мод тарих жил болгож албан ёсоор зарлаж байгаа. Энэ маань бол иргэд, ард түмэн, олон нийт суурьшлын бүсэд амьдарч байгаа орчны бохирдолтой холбоо бүхий асуудал энэ дээр давхар хөндөгдөж байгаа учраас зайлиггүй энэ суурьшлын бүсүүдэд мод тарьж ургуул гэдэг ийм чиглэлийг бол өгсөн.

Тухайлах юм бол Богд хан уулан дээр нийтдээ 2.5 сая ширхэг мод тарьж ургуулах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах гэх мэтчилнээр ингээд дараа дараагийн ажлууд төлөвлөгдөөд явж байгаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд тодруулъя гэж байна.

Х.Болорчулуун: Энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрдэнэс

Тавантолгой” 1350000 мод, Болдтөмөр Ерөө гол 1500000, Эрдэнэт үйлдвэр 4000700 гээд ингээд л явж өгсөн байна л даа. “Бороо гоулд” 880000 гээд л ийм мод тарина гээд. Тарих бол одоо яах вэ Үнэхээр ингээд тариад зүгээр орхичихвол хамгаалахгүй, хашаалахгүй, усалж арчлахгүй бол зүгээр 10 хувь нь ургах уу, үгүй юу бараг 100 хувь устана.

Тэгэхээр хамгаалж, хашаалах, усалж тордох чухал. Хамгийн гол нь энэ компаниудаар модны тоондоо биш, тарих модны тоондоо биш тэр хамгаалалтын хашааг нь гаргуулъя л даа. Уул уурхай газар шороо, байгалийн баялаг ашиглаж байна. Тэр газрыг нь компаниудыг тойруулаад мод тариулаад хашаалжуулчихъя, арчлахыг нь харин.../минут дуусав./

Б.Саранчимэг: Санал хэллээ. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бэт-Эрдэнэ: Жимсний модтой холбоотой асуудлаар Бат-Эрдэнэ сайд бас нэлээн тодорхой ярьчих шиг боллоо. Надад 1 ийм асуулт байгаад байгаа юм. Бид нар яг энийг “Тэрбум мод” хөтөлбөрийг далимдуулаад гэх юм уу, энэтэй уялдуулаад энэ жимсний мод өөрөөр хэлбэл жимс жимсгэнийнхээ хангамжийг сайжруулчихъя л гэсэн ийм бодол байгаад байгаа юм. Үндсэндээ бол манай 2-хон хувийг дотоодын жимс ер нь 2-хон хувь шүү дээ. Бусад нь 98 хувь. Одоо мэдэхгүй миний мэдэхийн л хэдэн жил 2 хувьтай л яваад байгаа. Бусад нь бол дандаа гаднаас орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр жимсний модон дээрээ нэлээн ач холбогдол нэгдүгээрт өгмөөр байна.

Хоёрдугаарт жимсний мод гэхээр нь ингээд л бүүр уулын мухар руу л ингээд л чулуудаад байх юм. Яг хотжилттойгоо холбоотойгоор энэ та бүхэн өөрсдөө гадаадад явж байхдаа хүртэл хардаг шүү дээ хот дотор шахуу энэ жимсний моднууд тэр тусмаа төрөл бүрийн жимсний янз янзын вино хийдэг энэ тэрээ гэсэн ус үзэм эд нар чинь хот

дотор хотын зүгээр гадна талаар бас яг цэцэрлэг маягаар бас тарьчихсан юм зөндөө байдаг шүү дээ. Тэгээд тийм байдал байдлаар тариач гэсэн ийм санал тавиад байгаа юм.

Хоёрдугаарт Улаанбаатар хотод, ер нь хотоо цэцэрлэгжүүлэх, цэцэрлэгт хүрээлэн бий болгох хүрээнд хэдий хэмжээний ер нь мод тарихаар төлөвлөөд байгаа юм? Хоёрдугаарт Бат-Эрдэнэ сайд яг энэтэй уялдуулаад аймаг, орон нутаг, жижиг хотууд, аймгийнхаа төвүүдийг ногоон байгууламжийг нь бий болгоход нөгөө миний яриад байгаа шүү дээ. Уулын мухарт аваачаад л мод таривал мод болчхож байгаа юм шиг тэрийгээ өөрсдийнхөө энэ таатай орчин, иргэдийнхээ амьдрах энэ орчныг таатай болгохын тулд энэ тэрбум модоо нааш нь татаж Улаанбаатар хотоо ч байдаг юм уу энэ Дархан, Сэлэнгэ, аймгийн төвүүдээ л сайхан ногоон болгох дээр ашигламаар байгаад байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр энэ рүү хэдэн хувь нь орж байгаа вэ? Ер нь улсын хэмжээний тэрбум модны? Аймаг, орон нутгийн сумын төвүүд, аймгийн төвүүд рүү хэдэн хувь нь орж ирж байгаа вэ? Тийм тоо байна уу?

Гуравдугаарт хуштайгаа ер нь ямаршуу бодлого барьж байгаа вэ? Хушин ой ер нь бол энэ Сибирь, Оросын Холбооны Улс манай Монгол Монголд байж байгаа шүү дээ энэ хушин ойнууд чинь. Тэгээд самар жил болгон аваачиж нүдсээр байгаад энэ хуш чинь ер нь бол алга болчих юм биш үү? Ер нь устаад алга болчих гээд байгаа юм биш үү бараг л? Тэгээд ийм байдалтай байж байгаад хушин ойгоо хамгаалах тэр нөгөө самар түүх нөхцөлийг ондоо болох тэр лиценз юмнууд өгөхдөө бол арай ондоо нөхцөлөөр авдаг эд нар боломж бололцоог нь хангах ямар бодлого барьж байгаа гэдэг дээр хэлээч гуравдугаарт

Дөрөвдүгээрт Саранчимэг дарга ер нь тодорхой хэмжээний үүрэг даалгавар эндээс бас өгөөд явах нь зүйтэй байх. Бид ер нь Байнгын хороон дээр тэгээд л нэг сонсдог. Сайд нар бол I удаагийн сайд дарга нар маань I удаагийн аргалаад л нэг сайхан хариулт өгөөд л ингээд л явчихвал болоо л гэсэн ийм байдалтай тэгээд буцаад цаашаа хараад хийж байгаа ажилд бид нар бас тэр болгон хяналт тавьж чаддаггүй.

Тийм болохоор тодорхой хэмжээний буцаж үүрэг даалгавраа өгөөд, буцаж эргэж хардаг нэг ийм холбоог нь гаргасан протокол юмаар бол бас үүрэг, даалгавар өгөөд явбал яасан юм бэ гэсэн ийм бодолтой байж байгаа шүү. Тэгээд хариулт сонсчихоод дахиад I асуух асуулт.

Б.Саранчимэг: 2 номерын микрофон, дараа нь 3 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Жимс, жимсгэнийн модтой холбоо бүхий асуудал дээр бид нар 2022 оны хаврын тайралтаас авхуулаад эхлүүлсэн. Тухайлах юм бол Хан-Уул дүүргийн 500 өрхөд бид нар жимс, жимсгэнийн модыг ойр орчмынх нь мод үржүүлэг хийдэг иргэдээс аваад, ойр орчимд нь айлуудаар тарааж тодорхой хэмжээнд суулгаж, ургуулах, хариуцлагажуулах энэ ажлыг бол хийгээд явж байгаа. Дутмаг байгаа гэдэгтэй санал нийлнэ. Энэ дээр бол бас Нийслэл, дүүргийн оролцоо маш өндөр чухал байгаа.

Өнгөрсөн жилийн Хан-Уул дүүргээс эхлүүлсэн энэ ажлыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам өөрөө хийсэн. Дүүргийн удирдлагууд энд бол бас тодорхой хэмжээнд оролцох зайлигүй шаардлагатай байгаа. Цэцэрлэгт хүрээлэн дээр бол нийтдээ 973 га газраас одоо 185 га газар бол төлөвлөлтөд орсон. Үлдсэн 700 гаран га газар төлөвлөлтөд ороогүй байгаа. Энэ дээр бол нийтдээ 1.2 сая ширхэг мод тарьж

ургуулах тооцоо гарчихсан, ТЭЗҮ хийгдэж байгаа. Энийг олон улсын миний түрүүний хэлдэг байгууллагуудаас туслалцаа, дэмжлэг авах хэмжээнд бол энэ төслүүдийг бид нар бас Англи хэл дээр болгоод манай Ойн агентлаг дээр хөөцөлдөөд явж байгаа төслүүдийн нэг.

10 гаран тэрбум төгрөг хамгийн багадаа шаардлагатай байгаа. Цэцэрлэгт хүрээлэн дээр 1.2 сая модыг тарьж ургуулахад. Аймаг, Нийслэл, суурин газруудтай холбоо бүхий асуудал дээр бол нийтдээ 130 орчим сая ширхэг модыг бол суурин газруудад тарьж ургуулсан байх ёстой гэдэг ийм тооцоолол гарсан.

Тухайлах юм бол Эрдэнэт хотод өнгөрсөн 2 дугаар сард бид нар ажилласан. Эрдэнэт хотод бол Эрдэнэт үйлдвэрийн тарьж ургуулах амлалт авсан 100 сая модны бол 10 сая модыг бол Эрдэнэт хотод суурьшлын бүс дээр тарьж ургуул гэдэг ийм чиглэлийг бол Эрдэнэт үйлдвэрт бид нар бас өгсөн байгаа.

Улаанбаатар хотод бол тооцоо судалгаа нь явж байгаа. Нийслэлийнхэн маань өөрсдөө хариулах ёстой болов уу гэж бодож байна. Тэрбум модтой холбоотой бид нар аль болох шилжүүлэх, тайрахгүй, огтлохгүй байх энэ асуудлыг хөндөж байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр судалгаанууд хийгдээд тодорхой бүсүүдээр бүсчилсэн байдлаар бид нар мод ашиглахыг хориглох, тайрч огтлох энэ асуудлыг бол бүрэн хориглохоор судалгаа, шинжилгээний ажлууд явагдаж байна.

Зайлиггүй төрийн стратегийн буюу дэд бүтэц татах, эрчим хүчний дэд бүтэц татах ч юм уу, зайлиггүй мод орж байгаа хэсгүүд бас бий. Энэ хэсгүүдийг бол модыг зайлиггүй шилжүүлэх ажлыг бол бид нар хийх ёстой гэдэг ийм үүрэг, даалгавруудыг аймгаас авхуулаад хийгээд явж байгаа.

Хуш модтой холбоотой асуудал байна. Хуш модон дээр бид нар саяхан бас уулзалтууд яг энэ хуш модтой холбоотой хэлэлцүүлгүүдийг бид нар хийсэн. Хуш модон дээр ер нь бол яг өнөөдөр байгаагаар бол 100 гаран, 120 орчим аж ахуй нэгжүүдэд зөвшөөрөл олгосон байгаа. Самар бэлтгэх зөвшөөрөл. Энэ зөвшөөрлийг бол бүгдийг нь эргэж харж хяна гэдэг шийдвэрийг өгсөн.

18 аж ахуй нэгжийн зөвшөөрлийг бид нар хүчингүй болгосон. Ер нь цаашидаа энэ хуш модон дээр бид нар ченжийн буюу бэлтгэлийн ажил хийдэг аж ахуй нэгжүүдийг бид нар бүгдийг нь цуцалгья гэж байгаа юм. Ийм бодлого гарна.

Ялангуяа энийг бэлтгэхдээ боловсруулаад гадагш нь гаргаж байгаа үйлдвэрүүд дээр бид нар зөвхөн зөвшөөрөл олгох, цаашидаа үйлдвэрийн шинж чанартай үйл ажиллагааг дэмжих, нэмүү өртгийг шингээх, тухайн үйлдвэрүүдэд бол бас хариуцлагын асуудлыг хөндөх учраас нөгөө өнгөрсөн 2022 онд хэрэгжүүлсэн заавал бүртгэлжүүл, заавал хариуцлагын гэрээ байгуул, заавал ой хуш мод руу гарч байгаа өөрсдөө гэрээ байгуулаад ажиллуулах гэж байгаа иргэдийг бол үнэмлэхжүүл. Энийг нь бол 2023 ондоо багтааж бүгдийг нь цахимжуул гэдэг ийм үүрэг, даалгавруудыг бол өгөөд явж байгаа.

Нөгөө талдаа хуш модон дээр хөндөгдөх сэдэв бол цэвдэг.../минут дуусав./

Б.Саранчимэг: 3 номер нэмж хариулъя. Хотоос өөрийгөө танилцуулаад яваарай.

С.Эрдэнэсайхан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн дарга Эрдэнэсайхан.

Улаанбаатар хотод нийтдээ 120 сая мод тарих “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд 120 сая мод тарихаар амлалт аваад хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс 55 сая мод бол байгалийн ногоон бүс хотын, 650 сая модыг хотын хотын суурьшлын бүс буюу нийтийн эзэмшил, хязгаарлагдмал тусгай хэрэгцээний гэсэн ногоон байгууламжид таригдахаар төлөвлөж байгаа юм.

Түрүүн жимсний модны тарьц, суулгацын асуудал яригдахад бид бүхэн нийтдээ 25 сая жимсний мод тарихаар хот суурин газар төлөвлөж байгаа юм. Бид нар “Тэрбум мод” үндэснийхээ хөдөлгөөнд суурь ажлаа бий болгохын тулд хот өөрөө мод үржүүлгийн талбай газартай болсон байгаа. Нийтдээ 32 га талбай дээр нийтдээ мод үржүүлгийн ажлыг эхлүүлсэн. Өнгөрсөн 2022 онд энэхүү ажлыг эхлүүлээд нийтдээ бол хайлаас, улиас гэх мэтчилэн моднуудыг эхлээд тарьж эхэлсэн байгаа. 15 аж ахуй нэгж байгууллагуудтай хамтраад энэхүү ажлыг эхлүүлсэн байж байгаа товчхондоо.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бэт-Эрдэнэ: Нэгдүгээрт надаа бүүр тодорхой хэлээд өгөөч. Одоо энэ модоо нүдээж байгаад самраа авдгийг энэ технологи өөрчлөх юм уу, өөрчлөхгүй юм уу? Би энийг л яриад байгаа юм л даа. Тэгэнгүүт л нөгөөдхөө чангалаад иргэдээ чангалаад явчих юм уу, яах юм? Эсвэл очиж уул модонд нь очиж шалгаж байгаад энэ самар авдаг технологи өөрчлөх юм уу, яах юм? Энэ дээр надад хэлж өгөөч.

Хоёрдугаарт гаднаас мод импортлох асуудлууд нэлээн хаалттай гэж би ойлгосон. Энэ нээж болохгүй юм уу? Тэгээд нэг юм болохоор л хэдүүлээ нөгөө төрийн алба чанга хатуу байдаг гэдгээр хамаг юмаа хааж хаячхаад л ерөөсөө. Буцаад нэг эргээд харах хэрэгтэй шүү дээ бид нар. Яг хэний

төлөө ажиллаж байгаа билээ. Юуны төлөө энэ төрийн албан хаагч чинь ажиллаж байгаа билээ. Энэ өнцгөөс нь харж байж зарим юмыг бол хаалт, боолтыг нь бол нээж байх ёстой шүү дээ бид нар. Тэгээд энэ хаалт, боолт чинь нээгдэх юм уу, үгүй юү? Хаалттай байгаа юу үгүй юү 2 дугаар асуулт.

Өшөө дахиад 1 минут авч болох уу, үгүй юү? Гуравдугаарт, минут авч болох уу?

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Бэт-Эрдэнэ: Гуравдугаарт, ингэмээр байна. Сум, сумын төв, аймгийн төв, хот, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар, Нийслэл яг хэдий хэмжээний га газар энэ гудамж талбай бүгдийг нь ингээд ногоон байгууламж бий болгох боломж бололцоотой вэ гэдгийг нь ингэж зураглалыг нь гаргаж байгаад бүүр сум болгонд, аймаг болгонд гаргаж байгаад бид жишээ нь Булган аймаг гэхэд хэд байлаа даа? 160-аад байсан билүү, сая мод ч гэл үү тийм тоо байсан санагдаад байх юм. Яг сум, сумуудад нь, жишээ нь тэгээд л Хялганат гээд тэгэхэд чинь л бас хөөрхөн хотхон байж байна. Яг хэдэн га дээр нь хотоо ногоон болгох юм? Аль аль гудамжнууд нь гаргах юм?

Булган сумын Булган аймгийн төв дээр ямар ямар гудамжнуудыг ногоон байгууламж болгох юм? Улаанбаатар хотод ямар ямар гудамжийг ногоон байгууламж болгох юм гээд ингээд зураглалыг нь гаргаж өгөөч. Зураглалыг нь гаргаад нэг ажиллаач. Тэгж байж наад хот чинь өөрөө ногоон болно шүү дээ. Тэгэхгүй хаашаа хатгасан газраа л ногоон болгох гээд.../минут дуусав./

Б.Саранчимэг: Төмөртөмөө дарга. Маш тодорхой асуулт асуусан хариулчих.

З.Төмөртөмөө: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Улаанбаатар хотод нийтдээ Захирагчийн ажлын албанаас буюу 135 га талбай дээр ногоон байгууламжийн арчилгааг бол хийдэг байгаа. Томоохон гудамж, цэцэрлэгт хүрээлэн гээд үндсэн ногоон байгууламжийн арчилгааг бас энэ 135 га талбай дээр арчилгаагаа хийж явдаг.

Ногоон байгууламж, Улаанбаатар хотыг цэцэрлэгжүүлэх мастер төлөвлөгөө гэж 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд нийтдээ Улаанбаатар хотыг ногоон бүсжүүлэх томоохон зураглалууд бүрэн хэмжээгээрээ гарсан байгаа. Түүнд бас presentation, мэдээлэл дунд бас товчхон гарч явсан байгаа. Энэ хүрээнд нийтдээ 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 28 метр квадратад нийт хүн амынхаа харьцуулсан талбайн хэмжээгээр 28 метр квадратад хүргэхээр тооцоолол гаргасан байгаа. Энэ хэмжээгээрээ бол.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд нэмж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Маш олон орны судалгаа үзсэн. Хэд хэдэн янзын арга байна. Бөмбөлөг ашиглаж байна. Энэ бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байсан жишээ юм байна лээ. Бөмбөлөг ашиглаж модны оройгоос тодорхой дээрээс нь буух хэлбэртэй ийм самар түүх, самар бэлтгэх ажил энэ бол ингээд бүтэлгүйтсэн. Нөгөө бөмбөлгөө алдчихсан юм байна лээ. Тэгээд нөгөөдөх нь бүүр хил зөрчөөд ингээд Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дээр очиж буугаад бөөн асуудал болсон.

Модонд чичиргээ үзүүлэх замаар самрыг түүх, бэлтгэх. Жишээлбэл үндсэн модоо ингэж чичиргээ өгч байж буулгах. Хоёр дахь.

Гурав дахь нь бол муна хэрэглэх буюу өнөөдөр Монгол Улсад хэрэглэгдээд байгаа модыг түншилж, тогишиж авах.

Энэ дээр бол олон янзын аргачлалаар, жишээлбэл зарим нь хаймар тавьсан, хаймар тавиагүй гээд ингээд маш олон аргачлалын асуудлууд бол байна.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бэт-Эрдэнэ: Улаанбаатар хот өөрсдөө тэр нэг тодорхой төлөвлөгөө юм байгаад байгаа юм шиг байна. Тэгээд Бат-Эрдэнэ сайд бас энэ дээр өөрөө анхаараад үзээч. Миний түрүүн хэлсэн сум, аймгийн төв, хот хотхон яг ямар гудамжнуудаа хэдэн нийт хэдэн га болж байгаа юм гэсэн тоо гаргаж ирээч л гээд байгаа байхгүй юу. Энийгээ цэцэрлэгжүүлъя. Энэ чинь өөрөө яг амьдрал руу орж ирсэн, хүн рүүгээ орж ирсэн хотынхоо ногоон байгууламжийг сайжруулсан тэгээд яг ард иргэдийнхээ амьдрах тийм таатай орчныг. Хамаагүй шүү дээ энэ нөгөө барилга байшингуудын дундах талбайнуудыг хүртэл бид нар ногоон байгууламжаа болгоё л доо. 2 байшингуудын дунд талын ногоон цэцэрлэгийг ногоон байгууламж болгоё л доо. Тэр хүүхдийн тоглоомыг ногоон байгууламж болгоё л доо. Яагаад болохгүй гэж. Заавал цэцэрлэгт хүрээлэн гээд 1 том хаашаа хашихаараа л тэр рүү бид нар мод тарьдаг байж болохгүй шүү дээ. Зүгээр энэ 2 байшингийн хоорондын өчнөөн олон шороо болчихсон газраа хэдүүлээ яагаад мод тарьж болохгүй гэж? Яагаад ногоон байгууламж болохгүй гэж. Энийгээ л тооц гээд байгаа байхгүй юу.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Тэр импорттой холбоотой асуудал бол хуульд өөрчлөлт орох ёстой. Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйл дээр ойд хориглох үйл ажиллагаа буюу 29-ийн 1.11 дээр зөвхөн энэ туршилт, судалгааны ажлаас бусад тохиолдолд хориглочихсон байгаа.

Тэгэхээр бид нар Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийж байна. Тэгээд энэ шинэчилсэн найруулгаараа явуулна гэвэл өргөн барьсны дараагаар. Яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэвэл нэмэлт, өөрчлөлт оруулаад явах ийм процесс үүсэх байх.

Мод үржүүлгийн компаниуд энэ дээр бол маш эсрэг байдаг. Манайх дээр маш удаа дараа мэдэгдэж байгаа энийг. Бид нар дотоодын мод үржүүлгийн компаниудаа дэмжих хандлага төр байх ёстой. Гаднаас импорт орж ирсэн тохиолдолд дотоодын мод үржүүлгийн компаниуд бол бүгдээрээ дампуурна гэдгийг бол удаа дараа манайд мэдэгдэж байгаа.

Тэр аймаг, нийслэл, хоттой холбоотой асуудал дээр тухайлбал би түрүүн бодит кэйс буюу Эрдэнэт хоттой холбоотой юм ярьсан. Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөг.../минут дуусав./

Б.Саранчимэг: Баярлалаа. Одоо Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал санаачилгаар хэрэгжүүлж байгаа энэ 1 тэрбум мод үндсэндээ бас ач холбогдол өгөхүйц ийм хэмжээнд хэрэгжиж байгаа гэж ингээж харж байгаа. 2 жил хэрэгжиж байна. 2 жилийн хугацаанд бид нар 17 сая мод тарьсан юм байна.

Тэгэхээр Монгол Улсын хувьд бол бас онцлог бий. Тал хээр, говийн бүс, хангайн бүс гээд энэ бүсчилсэн хэсгүүдэд мод тарихад мэдээж бас ургац насжилт гээд ингээд олон зүйлийн юмнудаас хамаарч байгаа. Ийм болохоор ер нь бол бас яг ийм ангилах тал дээр модоо ангилах тал дээр Байгаль орчны яам ямаршухан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм?

Дээр нь 1 мод гэдэг 1 амь. Тийм учраас бид мод тарихад нь нэг хэрэг, модоо бас арчилж ургуулах тал дээр бол

анхаарч ингээж ажиллах ёстой. Ийм учраас бол энэ бүртгэлжүүлэлтийг бас хийж байгаа гэж байна. Хэрхэн хийж байгаа юм? Ямар дата бааз, сан үүсгээд ингээд явж байгаа юм? Энэ дээр бас мэдээлэл өгөөдхөөч гэж ингээж хүсэж байна.

Мэдээж бас энэ үндэсний хөдөлгөөн бас тодорхой хэмжээгээр тодорхой салбаруудад бас ач холбогдол үзүүлэхүйц ийм хэмжээнд ахиц дэвшилүүд гаргахуйц ийм хэмжээний бас үйл ажиллагаа болж ингээж хэрэгжиж байгаа нь бас сайн хэрэг. Энэ дээр бас Байгаль орчны яам, ялангуяа энэ Ойн газар санал, санаачилгатай ажиллаж байгаа гэж бас ингээж харж байгаа. Тэр 1000 гаруй багшийг бэлтгэдэг бол маш сайн хэрэг. Монгол Улсын Их Сургуулийн хувьд тодорхой хэмжээгээр ингээд 2 дахь бакалаврын зэргийг энэ ойн чиглэлээр энэ хөтөлбөр хэрэгжүүлээд ингээд олгож байгаа нь бас сайн зүйл гэж бас үзэж байгаа.

Тэгээд та бүхэн маань бас хэлж байх шиг байна. Сүүлийн энэ 3 жилийн хугацаанд бид нарт бас 7000 мэргэжилтэн, ойн мэргэжилтэн хэрэгтэй байгаа гэж ингээж та бүхэн тооцоо гаргасан юм шиг байна. Тэгэхээр энэ ойн мэргэжилтнүүдийг бид нар бас ингээд бэлдээд бас бас болж байна. Дахиад цаашаа энэ хүмүүсээ ажлын байртай болгох. Энэ мэргэжилтнүүдээ бас ажиллуулах энэ талынх нь судалгаа юмнууд нь хэр байгаа юм бэ? Энэ бодлого чиглэл чинь бас цаашаа яваад байгаа юм бэ? Энэ дээр бас ямар судалгааг үндэслээд ингээд 7000 гаруй мэргэжилтэн хэрэгтэй байгаа гэж ингээж та бүхэн судалгаа гаргасан юм бэ гэж ингээж бас асуух асуулт байна.

Мэдээж энэ модны ер нь Монгол Улсын хувьд бол 7 хувийн ойттой, 70 гаруй хувь нь ингээд цөлжилтөд өртчихсөн ийм байдалтай байж байхад энэ говийн нөхцөлд мод тарих нь хамгийн чухал байж байгаа. Тэгэхээр яг энэ та бүгдийн өгсөн мэдээллийн дагуу бол үндсэндээ 88

хувьтай ургац нь их сайн байгаа гэж сайд мэдээлж байх шиг байна. Хамгийн их хэмжээгээр энэ Дорноговь аймаг, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд модыг бас 2 жилийн хугацаанд тарьсан байна.

Дундговь аймгийн хувьд үндсэндээ 2 сая 300 гаруй мод дахиж нэмэх тарих ийм шаардлагатай байгаа гэж ингэж судалгаа ирүүлсэн юм байна. Ер нь бол хөдөө аж ахуй ялангуяа орон нутгаас бол ард иргэд маань маш их хэмжээгээр энэ үйл ажиллагаанд оролцъё, орон нутгийн санал санаачилгыг дэмжээч, аж ахуй нэгжүүдийг оролцуулаач, ялангуяа яах вэ төрийн аж ахуй нэгжүүд бас тарьж болж байна. Хувийн аж ахуй нэгжүүдийг яаж дэмжих юм бэ бидэнд ингээд яаманд хандахаар ямар нэгэн байдлаар дорвитой хариу өгдөггүй. Ямар нэгэн дэмжиж туслалцаа үзүүлдэггүй гэдэг ийм зүйлүүдийг бас ард иргэд маань бас ирүүлээд байдаг. Ийм хүсэлттэй ард иргэд их олон байдаг.

Тэгэхээр энэ дээр яам ямар бодлого авч хэрэгжүүлж байгаа юм бэ? Уул уурхайн компаниуд 1.5 тэрбум мод тарихаар амласан юм байна. Энэ тоо хэр бодитой тоо юм бэ? Энэ амлалтыг, биелэлтийг хангуулахад ер нь ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байгаа юм бэ гээд ингээд энэ хэд хэдэн зүйлийн асуултыг Байгаль орчны яаманд тавиадахъя.

Б.Саранчимэг: Маш чухал асуулт асуулаа. Тэгэхээр тэр бүртгэлжүүлэлт гэж байгаа тэр дээр бас хот бас дахиад нэмээд хариулчхаарай.

Бат-Эрдэнэ сайдыг хариулахыг хүсэж байна. 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Ургалт дээр анхаарах мод амилуулах асуудал гээд энэ дээр бол ерөөсөө бид нар арчилгааг бол шууд мод үржүүлгийн компаниудтай хийхээр л явж байгаа юм.

Өөрөөр хэлбэл мод үржүүлгийн компаниуд өөрсдөө тарьж ургуул, тарьж ургуулсан модоо өөрсдөө 3-5 жилийн хугацаанд арчил, үхэх юм бол мод үржүүлгийнхээ газраас өөрсдөө дараагийн модоо авчирч суулгаад, төртэй байгуулсан эсвэл уул уурхайн компанитай байгуулсан тухайн санхүүжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээгээ мөрдөж ажилла гэдэг ийм зарчим дээр л явж байгаа юм. Энэ утгаараа уул уурхайн 21 компанитай бид нар тодорхой компаниудтай нь гэрээ хэлцэл хийгээд, гуравласан гэрээнүүд хийгээд эхэлчихсэн явж байна.

Өнөөдөр бол тэр уул уурхайн компаниудын 1.5 тэрбум бол улсын хэмжээнд, уул уурхайн компаниуд бол 608 сая мод тарьж ургуулах авсан зөвхөн амлалтын асуудлуудыг бид нар хөндөж байгаа юм. Зарим уул уурхайн компаниуд бол 0 тарилттай байгаа. Тухайлбал анхны хэлсэн амлалтаа биелүүлээгүй байна гэсэн үг. Энэ компаниуд дээр бид нар юу гэдэг юм цаашидаа хэрхэн хамтран ажиллах энэ бол зөвхөн мод тарихаасаа гадна заримыг нь бол бид нар дүйцүүлэх хэлбэр дээр нөхөн сэргээлт дээр авч ажиллуулах энэ тэр гээд ажлуудыг бол бид нар яриа хэлцлийн түвшинд хийгээд явж байгаа.

Мэргэжилтэн бэлтгэх, ажлын байраар хангахтай холбоо бүхий асуудлууд байна. Төрөөс барьж байгаа бодлого буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас барьж байгаа бодлого бол ерөөсөө мод үржүүлгийн компаниудыг иргэн, аж ахуй нэгжүүдийг л дэмжих. Энийг л бид нар хийнэ. Энэ дээр тухайн уул уурхайн компаниуд байдаг юм уу, өнөөдөр хөндөгдөөд байгаа нь яагаад уул уурхайн компаниуд хөндөгдөөд байгаа вэ гэхээр ихэвчлэн уул уурхайн чиглэлээр явж байгаа ажлууд тэрэнд өөрөө зайлигүй нөхөн сэргээлтийн ажлууд хийгддэг. Өөрсдөө нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагтаа мод тарьж ургуулья гэдэг. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих ийм хандлагууд

илэрхийлсэн нь уул уурхайн компаниуд хэлэгдээд яваад байгаа учраас энэ асуудал хөндөгдөөд байгаа юм.

Нийтдээ тарьж ургуулах модны тоо ширхэг болон даац, байр зүйгээс шалтгаалалтайгаар 1 мэргэжилтэнд ноогдох гэдэг утгаар нь бид нар 7000 мэргэжилтэн гэдэг тооцоо, судалгааг гаргаж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл 1 хүн тэрбум мод тарих боломжгүй. Тэр утга агуулгынхаа хүрээнд 7000 гэдэг тоо бол гарч ирсэн утга учир нь бол тэнд байгаа юм гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Орон нутгийн санаачилгуудыг дэмжээд явж байгаа. Сая би тухайн танилцуулга дээр ч гэсэн хэлсэн. Тэгэхдээ энэ бол зөвхөн өнөөдрийн байгаа төсөв, мөнгөнийхөө хэмжээнд л явж байгаа ажил. Цаашидаа бид нар хувийн хэвшилтэй хамтарсан байдлаар, олон улсын байгууллагуудтай хамтарсан байдлаар энийг хэрэгжүүлэхгүй бол төр энийг бүгдийг хийх боломжгүй.

Ялангуяа өнгөрсөн жилийн тэр 21 сум дундын ойн ангид нийлүүлсэн анжис, модны нүх ухагч, 21 тракторын иж бүрдэл, 347 сая төгрөгөөр 120 метр квадрат талбайтай дуслын болон мананцар усалгааны систем бүхий 21 ширхэг хүлэмж гэдэг ч юм уу. Энэ бол ихэнх нь дандаа төрийн мөнгөөр явж байгаа нэг талдаа ажлууд.

Тэгэхээр бид нар цаашидаа жишээлбэл Оюутолгой компанитай байгуулсан 100 сая мод тарьж ургуулах дээр тодорхой хэмжээг дүйцүүлэх хэлбэр дээр тэр дээр нөхөн сэргээлт нэг талдаа, нөгөө талдаа 2023 оны хувьд бол 2 тэрбум төгрөгөөр тодорхой тоног төхөөрөмж худалдаж авч, иргэд, аж ахуй нэгж мод үржүүлгийн компаниудад нийлүүлэхээр ийм гэрээ хэлцлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгуулаад явж байгаа.

Ингээж явахгүй бол яг төрийн өөрийн тавигдаж байгаа татварт төлөгчдийн мөнгөөр бид нар нэг талдаа татвар төлөгчдөөс мөнгө цуглуулаад, нөгөө талдаа бусад аж ахуй нэгж, иргэдэд шууд тоног төхөөрөмж худалдаж аваад өгөөд байх нь өөрөө бас зүүд нийцэхгүй гэдэг утга агуулгын хүрээнд тэр нь өөрөө ихэвчлэн тоног төхөөрөмжтэй холбоо бүхий асуудлууд, худаг гаргахтай холбоо бүхий асуудлууд, механикжуулалттай холбоо бүхий асуудлууд, мөн тарьц, суулгацыг хүртэл худалдаж авч өгөхтэй холбоо бүхий асуудлууд хөндөгдөөд байгаа юм.

Тэгээд энэ мөнгөн дүнгийн тооцоогоор бол энэ бол 50 гаран тэрбум төгрөгийн төсөв зайлиггүй шаардлагатай ийм төсөв гарсан. Өнөөдөр мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн компанид гэхэд жишээлбэл хамгийн багадаа 7 тэрбум төгрөгөөр.../минут дуусав./

Б.Саранчимэг: 3 номер нэмж хариулъя. Бүртгэлжүүлэлт дээр хэлбэл.

С.Эрдэнэсайхан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хот модыг бүртгэлжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулаад явж байгаа. Өнөөдрийн байдлаар Green city, UB.mn гээд 1 аппликэйшин бий болгоод Улаанбаатар хотын Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй дүүргийн модыг бүртгэсэн явж байгаа. Энийг яг цэгэн байдлаар буюу хаана ямар байришил дээр хэчнээн мод байгаа талаарх яг нарийвчилсан тоог гаргаад явж байна. Энэ аппликэйшнийг цаашиа энэ жилийн хувьд хөрөнгөжүүлээд нийслэлийн 6 дүүргийн хувьд бүтэн бас бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулаад явж байна.

Тоон мэдээлэлтэй холбоотойгоор эхний 3 дүүргийн байдлаар нийтдээ модны тоо бол 30558 ширхэг яг бүртгэжилсэн хэлбэрээр мод томоохон төрлийн гоёлын мод, бут, сөөг байна гэж тооцоолол гарсан явж байна.

Б.Саранчимэг: Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Г.Мөнхцэцэг: Нийслэлийн хувьд ингээд аппликэйшн гаргаад ингээд бүртгэлжүүлээд болж байна. Хөдөө орон нутагт ийм бололцоо юмнууд маань хэр байгаа вэ Бат-Эрдэнэ сайдаа? Энэ дээр бололцоо нөхцөлүүд нь байна уу гэж.

Тэгээд та бүгдийн өгсөн энэ бас мэдээлэл дотор 2023 онд тарих модны тоог ингээд аймгаар нь гаргаад ингээд ирсэн байна л даа. Тэгэхээр хамгийн их мод тарих шаардлагатай байгаа аймгийн тоонд энэ Завхан аймаг, Дундговь аймаг, Сүхбаатар аймаг гээд ингээд аймгуудын бүртгэл, тооцооллууд гарсан юм шиг байна.

Тэгэхээр тухайлбал энэ орон нутгууд энэ моднуудаа хаанаас авч тийм хаанаас авч ургуулах тарих тал дээр ажиллах ёстой юм бэ гэдэг энэ тоо мэдээ, мэдээллийг орон нутгуудад өгсөн үү? Ямар байдлаар зохицуулалт хийх гэж байгаа юм бэ?

Б.Саранчимэг: 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Нэмэлт хариултыг өгье. *terbutmod.mn*, *modlog.mn* гээд би түрүүн хэлсэн. *Terbutmod.mn* дээр бол ялангуяа мод үржүүлгийн компаниудын бүртгэлжүүлэлтийн асуудлууд, дээрээс нь мод үржүүлгийн компаниудыг албан ёсоор *terbutmod.mn* дотор оруулчихсан учраас тухайн компаниуд маань тарьж ургуулж байгаа моднуудаа бол шууд өөрсдөө бүртгэл хийж тэнд оруулахаар зохион байгуулалтыг бид нар хийсэн байгаа. Мод үржүүлгийн компаниудын хувьд. Иргэд бас орж байгаа.

Modlog.mn гэдэг сайтын хувьд бол арилжааных. Өөрөөр хэлбэл Сэлэнгэ аймагт мод үржүүлэг хийж байгаа иргэн, аж ахуй нэгж бол шууд *modlog.mn*-д өөрийнхөө модны зургийг

мэдээлэлтэй нь, үнэ өртөгтэй нь тавихад өөр газраас худалдан авалт хийх бүрэн дүүрэн боломжоор хангаад өгчхөж байгаа гэсэн үг.

Аймгууд дээр тарьж ургуулж байгаа моднуудын хувьд бол модыг ялангуяа жишээлбэл Сэлэнгэ аймаг бол хангайн бүс дээр мод нийлүүлэгч аймаг бол.../минут дуусав./

Б.Саранчимэг: Баярлалаа. Бат-Эрдэнэ сайдад 1 минут өгье. Дахиад нэмэлт хариултаа өгчих. 2 номерын микрофон уу?

Б.Бат-Эрдэнэ: Сэлэнгэ аймгийн хувьд сая иргэдийн төлөөлөгчдийнхөө хурлаар оруулаад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй холбоотой тарьж ургуулах мод зурвасаас авхуулаад бүх төлөвлөлтүүдээ баталсан байна лээ.

Хангайн бүс, төвийн бүс дээр бол нийлүүлэгч аймаг болъё гэдэг ийм зорилгоо тавиад явж байгаа. 2022 онд бол 8 сая тарьц, суулгацын бэлдэцтэй байсан бол 2023 онд бол 24 сая ширхэгт хүргэсэн гэдэг ийм мэдээллүүд бид нарт ирсэн. 2023 онд бол 8 сая ширхэг модыг шууд тарьж байгуулна гэдэг ийм тооцоолол дээр бол явж байгаа.

Говийн аймгуудаар бол Өмнөговь аймаг бол тарьц, суулгац нийлүүлэх аймаг болж өөрсдөө бас саналаа ирүүлсэн. Үүнийхээ хүрээнд, хамтын ажиллагааны хүрээнд Дорноговь, Дундговь гээд энэ говийн бүсийн аймгууд дээр бол модыг шууд нийлүүлнэ гэдэг хэлбэр дээр явж байгаа.

Аймгуудыг бол бид нар шууд шууд холболтуудыг хийж байгаа. Яагаад тухайн аймгуудыг би дурдаад байна гэхээр тухайн мод үржүүлгийн газруудыг тэнд төвлөрүүлэх, газар олголтыг хийх, нийлүүлэх гэдэг хэлбэр дээр дагнасан хэлбэрээр тухайн аймгууд маань өөрсдөө шууд бусад аймгуудтайгаа хамтраад ажиллаад бүс нутгийн хэмжээнд ажиллая гэсэн саналуудыг ирснийг

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас дэмжсэн учраас явж байгаа юм.

Ер нь бол зүгээр жишээлэх юм бол Завхан аймаг байдаг юм уу, Ховд аймаг байдаг юм уу тухайн хөрснөөсөө авхуулаад бусад зэргэлдээ гэдэг юм уу, ижил төстэй хөрстэй газруудаасаа мод тарьц, суулгац авах энэ ажлуудыг зохион байгуулах шаардлагатай.

Тухайлах юм бол Өмнөговь аймагт байгаа мод үржүүлгийн газраас Завхан аймаг руу тарьц, суулгац явах боломжгүй. Энэ утга, агуулахынхаа хүрээнд бид нар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бол бүс гэдэг энэ хэлбэрийг бол хөрс болон байр зүйгээс шалтгаалсан байдлаар бид нар авч хэрэгжүүлж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бас бид нар энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт мөн Улаанбаатар хотын ногоон байгууламжийн төлөвлөлт, өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг сонслоо. Тэгэхээр энэ мэдээлэлтэй холбогдуулж бас тодруулж асуух зүйлүүд байна.

Байгаль орчныг хамгаалах консервац бүлэг бас Улсын Их Хуралд байгуулагдсан. Бид илүү их санаачлаад улсын төсөвт бас ингээд задлаад хортон шавжийг устгах, энэ хүр хорхойг устгах энэ төсвийг бас тавьж өгсөн. Тэгэхээр энэ төсөв маань өнөөдөр аль хэр үр дүнтэй зарцуулагдаж байгаа вэ? Гар аргаар хийгдэх гээд байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа учраас энэ тал дээр бас тодруулж хариулж өгөөч.

Тэгэхгүй бол энэ 6 сар гэхэд энэ хорхой, шавжаа устгахгүй бол бүх энэ ойнууд чинь устгах гээд байна гэдгийг бас энэ Тэмүүлэн гишүүн бас хэлсэн. Тэгэхээр энэ дээр тодруулж хариулж өгөөч.

Нөгөө талаар энэ “Тэрбум мод” тарих хөдөлгөөн, хүнсний хангамж,

хүнсний аюулгүй байдлыг Монгол Улсын Ерөнхийлөгч үнэхээр санаачлаад бас үндэсний хөдөлгөөн болгож чадаж байгаа нь үнэхээр бахархалтай. Тэгэхээр бид нар энэ дээр бас их сайхан стратеги төлөвлөгөө гараад, энийг ажил болгох гээд ингээд хамтраад явж байна.

Дээр нь ингээд явж байхад манай бойжуулах талбай хийх, мод ногоогоо тарих мөн хүнсээ тарих энэ нөхцөл бололцоо дээр нь газрыг дуудлага худалдаагаар л өгнө гээд ингэчихдэг. Тэгэхээр нөгөө иргэддээ үнэхээр хүндрэлтэй байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ тал дээрх яг ямар эрх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх вэ? Газрын хууль Засгийн газраас орж ирэхээс өмнө энэ тал дээр үнэхээр хэрэглэхгүй бол 1 жилийн өмнө, 2 жилийн дараа хураачихдаг үнэхээр энийгээ зориулалтаар нь хэрэглэж байвал бас ингээд төрөөс бодлогоор дэмждэг энэ нөхцөл байдлыг бас бүрдүүлж өгмөөр байгаа юм.

Улаанбаатар хотын бас ерөнхий төлөвлөгөө энэ ногоон байгууламжийн талаар бас мэдээлэл сонслоо. Тэгэхээр энэ мэдээлэлтэй холбогдуулаад бас ингэж тодруулж асуух зүйлүүд байгаа юм. Тэгээд бас миний хувьд бас энэ Баянзүрх дүүргээс сонгогдоод 26 дугаар хороо бол яах аргагүй бас тэндээс сонгогдсон гишүүний хувьд мөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын хувьд 26 дугаар хорооны Засаг дарга буюу бас хэдэн зуун хүний гарын үсэгтэй ийм гомдлыг ирүүлсэн. Тэгэхээр энэ гомдлын дагуу газар дээр нь очиж ажилласан. Бодит мэдээлэл байхгүй байсан учраас газар дээр нь очиж ажилласан.

Тэгэхээр энэ дээр бас тодорхой хариулт өгөөч. Би тодорхой асуулт асууя. Ямар шалгуураар энэ KFC Land-ыг сонгон шалгаруулсан юм бэ? Газар дээр нь очоод үзэхээр тэр чинь яг үнэхээр олон жилийн хөдөлмөр шингэсэн цэцэрлэгт хүрээлэнгийн хөрс ямар билээ хад хайрга болсон энийг маш их зузаалж

ингээж хар шороог нь авчраад тэр зүлгийг ургуулахын тулд маш олон хүний хөдөлмөр, маш их хөрөнгө зарчихсан байгаа. Энэ хөрсийг нь очоод 1.1 га-г бүүр ингээд устгаад ингээд явчихсан байгаа. Яг газар дээр нь очоод уулзахаар Ерөнхий архитектур болоод одоо энэ анхны зураг төслийн автартайгаа яаж зөвшилцөөгүй, Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчөөр ороогүй ийм байдал харагдсан. Тэгэхээр энийг яагаад энэ тохижилтын ажлыг ингээд шийдвэр нь гараагүй үед ийм ингээж шууд ажлаа эхэлсэн юм бэ гэсэн нэг ийм асуулт байна. Одоо яг ингээж ажиллах дээр хэн зөвшөөрөл олгосон юм бэ?

Нөгөө талаар газар дээр нь очоод үзэхээр 40-өөд түц байгаа гэсэн боловч ингээд тэнчээ байсан иргэд тэнчээ чинь 80 гаруй түц байна гээд 81 түц болж таарсан. Энийг нээлттэй сонгон шалгаруулалтаар өгдөггүй гээд 26 дугаар хорооны иргэд бас тэнчээ ярьж байсан.

Тэгэхээр энийгээ өмнө нь бол бас Нийслэлийн өмч газар дээр яг энэ нь нээлттэй тендер болоод явдаг байсан бол одоо бүүр 81 түц болчихсон. Хотын өнгө үзэмж, бүүр ялангуяа Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн концепцыг эвдчихсэн ийм байгааг бас Байгаль орчны сайд бид нар яг холбогдох харьяаллын хүмүүс очиж ажилласан байгаа.

Тэгэхээр хамгийн гол нь бид нар хувийн хэвилийгээ үгүйсгээд, хийсэн бүтээх гээд байгаа хөдөлмөрийг нь үгүйсгэж байгаа юм биш. Хамгийн гол нь энэ аливаа ажил ерөнхий төлөвлөгөөнийхөө дагуу л хийгдэх ёстой. Тэр утгаараа энэ төлөвлөлтийг нь эвдээд энэ ажиллаад шууд эхэлчихдэг нь ямар учиртай юм бэ? Энэ дээр бас яг асуултуудад тодорхой хариулж өгөхийг хүсэж байна. Тэгээд хамгийн гол нь бас олон нийт бол ногоон байгууламжаа устгаад дээр нь тарьсан олон жил таригдсан моднуудаа бас устгаад, зүлгээ устгаад ингээд хүнд механизм оруулаад ингээд түрчихсэн байсан.

Тэгэхээр энэ дээр өнөөдрийн тэр төлөвлөлт 40 хувь нь ногоон байгууламж гээд ороод ирж байгаа энэ цаг үед Үндэсний цэцэрлэгт хүрээлэн чинь өөрөө 85 хувь нь ногоон байгууламж гээд. Хэрвээ тэгэх л байсан юм бол өөр газарт өгөөд, заавал ногоон байгууламжтай газраа өгдөг нь ямар учиртай юм бэ? Энэ дээр хариулт авъя.

Нөгөө талаар иргэд өөрсдөө модоо тарьдаг миний тарьсан мод алга болчихсон байна гээд гомдол ирж байна лээ. Энэ дээр тодорхой хариултуудыг авъя. Төмөртөмөө даргыг хариулт өгөхийг хүсэж байна. Баярлалаа. 3 номер.

3.Төмөртөмөө: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Цэцэрлэгт хүрээлэнтэй холбоотой асуудал нэлээн олон нийтийн анхаарлын төвд орж 2 хуваагдсан ийм байдалтай өрнөж байх шиг байна. Улаанбаатар хотын удирдлагуудын зүгээс Цэцэрлэгт хүрээлэнгийн даргатай холбоотой асуудал дээр ажилтнаа шууд буруутгах эрх зүйн үндэслэл нэгдүгээрт байхгүй болчихоод байгаа юм. Ерөөсөө энэ Цэцэрлэгт хүрээлэнгийн 973 га газрын 183 га-г газар тохижилт, ногоон байгууламж хийх Ерөнхий төлөвлөгөө 2014 онд баталчихсан байгаа юм.

Тэгэхээр энэ ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газар дээр KFC буюу энэ “Таванбогд” хувийн аж ахуй нэгжтэй өөрийн эрх, үүргийн хүрээнд тодорхой гэрээ байгуулсан асуудал нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь иргэдийн шүүмжийг хүлээж авч байгаа юм. Иргэд бол мэдээж энэ ногоон байгууламж сүйтгэж байна, энэ цементэн ширэнгэ хэрэггүй гэдэг ийм байдлаар иргэдийн хандаж байгааг ойлгож байгаа.

Тэгэхээр хууль, журмын хүрээнд бол яг хуулиа харахаар ерөнхий төлөвлөгөө нь батлагдчихсан ийм газар хувийн аж ахуйн нэгжтэй хөрөнгө оруулалт

татаад л хийчихсэн ийм гэрээний асуудал болчихоод таарч байгаа юм. Үүнтэй холбоотойгоор бид нар дараа дараагийн удаа ерөөсөө энэ нийтийн эдэлбэр газар дээр тодорхой тохижилт хийх, ногоон байгууламжтай холбоотой асуудал дээр заавал иргэдийн саналыг асуудаг болох.

Хоёрдугаарт нь хотын даргын зөвлөлийн хурлаар оруулж хамгийн сүүлд Нийслэлийн иргэдийн хурлаар эцэслэн шийдвэр гарсны дараа л энэ төрлийн ажлууд хийдэг болох ийм л тодорхой харилцааны журмын шинэчлэлт хийхээр бид нар ажиллаж байна. Өөр арга байхгүй.

Одоо бол энэ үйл ажиллагаа цааш үргэлжлэх, зогсох асуудал бол цэвэр Улаанбаатар хотын даргын бүрэн эрхийн асуудал гэж ингэж ойлгож болно. Ер нь ийм төрлийн үйл ажиллагааг эрхлэхдээ энэ том сургамж боллоо. Иргэдэд нээлттэй төслөө танилцуулдаг, нээлттэй сонгон шалгаруулалт явагддаг тэр нь саяын шат, процессоор ингээд л дамжчихдаг юм бол ийм төрлийн маргаан ахиж гарахгүй байх гэсэн ийм ойлголттой байгаа.

Түүцийн асуудлыг бол Цэцэрлэгт хүрээлэн манай Нийслэлийн өмчийн харилцааны газар 2 ийм гуравласан гэрээ байгуулж тодорхой үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

Ер нь энэ түүцтэй холбоотой асуудлууд дээр бас л нэг ийм ойлголт байгаад байгаа юм. Энэ Улаанбаатар хотын автобусны буудал дээр байгаа түүцүүд дүүрэг болгон дээр л байна. Сая 1 дэх өдөр буюу өчигдөр Улаанбаатар хотын дарга дүүргийн Засаг дарга нартай хамт түүц эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзсан. Үүн дээрээ ч тодорхой хэлсэн. Яг энэ төлөвлөгөөний дагуу хууль, дүрэм зөрчсөн тохиолдолд бид нар ажиллуулж чадахгүй. Хотын өнгө үзэмжтэй холбоотой ч асуудлууд байна гэж. Хэрэв ингээд хууль, дүрэм зөрчиж байна боломж гүйгээд л хуулийн

хүрээнд шаардлага биелүүлчихээр иргэд, аж ахуй, иргэд босоод ирдэг, жагсаал цуглаан болдог. Дээр, доороос шийдвэрүүд орж ирдэг. Энэ иргэдийнхээ энэ худалдан борлуулалтын эх, орлогоо өсгөх юман дээр та нар саад, хориг тавьж болохгүй шүү дээ гэдэг ийм л бид нар бас олон нийтийн шүүмжлэлтэй нүүр тулдаг нь үнэн. Ингээд л иргэд дахиад л 2 хуваагддаг.

Ер нь цаашидаа шууд хууль, дүрмийг хатуу үед нь хатуу биелүүлж, энэ зөвшөөрөлгүй түүц эрхэлж байгаа эдгээр хүмүүстэй бол тэмцэхээс өөр арга зам байхгүй л юм байна лээ. Тэх. Цэцэрлэгт хүрээлэн мөн адил. Цэцэрлэгт хүрээлэнгийн ачаалал бол дийлдэхээ больсон юм шүү дээ. Та мэднэ зүүн талын төв хаалган дээр бол ерөөсөө л бужигнасан ийм үймэнтэй болсон. Харин энэ Оюунзул захирал санаачилга гаргаж хот дээр бид нар тодорхой мөнгө тавьж, баруун талд 500 машины зогсоол бүхий зогсоолыг бий болгосон. Тэнд мөн жишээлбэл хэрхэн үйл ажиллагаа явуулах юм. Энийг бид нар бас л яг саяын хэлсэн нийтээр хэлэлцүүлж, тодорхой стандарт тогтоож л энэ ажлуудыг эхлүүлж байхгүй бол дахиад л ийм шүүмжлэлүүд гарна. Иргэдийн тавьж байгаа санал, санаачилга шүүмж бол зөв гэж Улаанбаатар хотын удирдлагууд хүлээж авч ийм.../минут дуусав./

Б.Саранчимэг: Би тодруулж асууя. Ерөнхий төлөлтийг эвдээд, яагаад ногоон байгууламжийг эвдээд дахиж сүйтгээд гээд бүтээн байгуулалт хийх гээд байгаа юм бэ? Өөр газар байгаа шүү дээ. Улаанбаатар хотод өөр дүүргүүд ч гэсэн тэр Баянзүрх дүүрэг дээр ч гэсэн олон улсын цэцэрлэгт хүрээлэн байгаад байна. Хамгийн төвд ориш тэр хэсгийн олон жилийн хөдөлмөр шингэсэн тэр ногоон байгууламжийг, тэр зүлгийг бий болгохын тулд маш их хөдөлмөр зарж, маш их хар шороо авчирч, тэр хад, хайргыг өөрчилсөн.

Тэгэхээр 14 онд яг энд ийм төлөвлөлт байгаагүй. Одоо ч байхгүй

байгаа. Энэ төлөлтөө өнөөдөр батлуулаагүй. Ялангуяа бас анхны зураг хийсэн төслийн тэр дарга нь оччихсон Мижиддорж чинь өөрөө оччихсон, мөн 26 дугаар хорооны иргэд оччихсон, Засаг дарга нь оччихсон гомдол нь яагаад ногоон байгууламжаа эвдээд нөгөө тэрбум мод тарина гээд байсан чинь дахиад тэр тарьсан, Бат-Эрдэнэ сайд хүртэл хэлж байсан энэ 82 модоо ингээд шилжүүлэхийг бас хүлээн зөвшөөрөхгүй гээд. Тэгэхээр энийг яагаад ингэж хийж байгаа юм бэ? Ямар нэгэн хувь хүн рүү биш, ямар нэгэн байгууллагын том бүтээн босголт руу бид нар дайраагүй шүү дээ. Бид нар зарчмын л юм ярьж байгаа.

Хамгийн гол нь дахиад өөр 1 компани ирээд энэ хэсэгт нь зайтай юм байна гээд дахиад төлөвлөлт хийгээд бас 2 дахь хашаа баригдчихсан байна гээд одоо энэ сошиалаар яваад байх юм. Тэр нэг хашаагаа болиулаад дахиад өөр газар нь тэгвэл төлөвлөлтөө батлуулаад хий л дээ.

Тэгээд яг энийг Цэцэрлэгт хүрээлэнгийн даргын эрх мэдлийн хүрээнд очиж ингэж ухсан гэж ойлгож болох уу? 3 номерын микрофон

3.Төмөртөмөө: Тийм, тийм тэгж хэлж болно. Цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлагууд өөрсдөө яг хуулийн хүрээнд шийдвэр гаргаад явсан л гэж ингэж ойлгож болно. Түрүүний миний хэлснээр Хотын даргын зөвлөлийн хурал, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орох тодорхой журам алга байна. Тийм учраас бид нар яг тэр байгууллага удирдаж байгаа хүний өөрийн эрх мэдлийн л хэмжээний асуудал болчихоод байгаа юм.

Тийм учраас бид нар журам гаргая л гэж байгаа юм. 2014 оны ерөнхий төлөвлөгөө дээр тухайн энэ таны хэлээд байгаа бид бүхний яриад байгаа энэ хэсэг бол төлөвлөгөөнд тохижилтын төлөвлөгөөнд ялт ч үгүй орчихсон юм байна лээ. Тийм учраас бид нар энэ

асуудал дээр дахиж иргэдийн саналыг ав. Өөрсдөө тэр тодорхой компани нь ч гэсэн тодорхой иргэдийн саналыг аваад эхэлсэн байна лээ.

Тэгээд иргэдийн энэ тавиад байгаа шүүмжлэлийг ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр ерөөсөө эргээд энэ 14 оны эс үгүй бол тогтоол руу бид нар эргэж харах, цааши цаашидаа ер нь нийтийн эзэмшлийн талбар, ногоон байгууламжтай холбоотой асуудал дээр хэрхэн энэ харилцаан дээр журам тогтоох вэ л гэдэг ийм л асуудлыг ярьж байгаа юм.

Б.Саранчимэг: Төмөртөмөө дарга та яг одоо энэ ногоон байгууламжийг хариуцаж байгаа, ногоон бодлогыг, хотын бодлогыг хариуцаж байгаа хүний хувьд 2014 онд би өөрөө яг удирдаад явж байсан. Ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Батлуулсныхаа дагуу энэ ажлууд бүтээн байгуулалтууд хийгдсэн. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн байна 85 хувь нь ногоон байгууламж байна гэж батлагдсан. Тэнчээ журам гэж ерөөсөө журам байхгүй гэж яриад байх юм. Битгий тэгээч дээ. Тэнчээ чинь яг ногоон байгууламж байна гээд ногоон байгууламж нь хийгдчихсэн газар байхгүй юу. Тэгэхгүй тэр дээр, нэгэн дээр нь ингэж яваад ингэж болохгүй шүү дээ. Та нар яг ногоон байгууламж хийгдчихсэн газрыг заавал сонгоод, тэгээд өнөөдөр эрх хүрээнийхээ хувьд Цэцэрлэгт хүрээлэнгийн даргад тийм эрх байхгүй шүү дээ.

3.Төмөртөмөө: Тийм яах вэ би таны хэлж байгааг бол маш сайн ойлгуул байх юм. Тэгээд цагаан дээр хараар бичсэн юмыг бол бид нар үнэхээр яаж ч болохгүй юм. Жишээлбэл энэ 183 га талбайн 100 хувь гэж авч үзэх юм бол төлөвлөгөө хийгдсэн. Үүний 15 хувь нь тохижилт хийгдэх ийм даалгавартай л байгаад байгаа юм. Тэгээд энэ 15 хувь дотор л энэ тухайн олон нийтийн шүүмжлэлд өртөөд байгаа энэ газар л орчихоод байгаа юм.

Тийм учраас бид нар дараа дараа энэ нөхцөл байдал үүсэхгүйн тулд тодорхой иргэдийн саналыг асуудаг болъё. Дээрээс нь Нийслэлийн иргэдийн хурал гэж юуны төлөө байгууллага байгаа билээ энэ. Нийслэлийн иргэдийн хурлаар оруулж эцсийн шийдвэрийг гаргадаг болъё л гээд. Ингэж байж л маргаан зогсоно л доо. Тэгэхээс бол яг энэ хуулийн хүрээний юмаа ярихаар бид нар хэн нэгнийг буруутгаж ерөөсөө болохгүй болчхоод байгаа юм. Тэх.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд нөгөө хортон шавж юун дээр хариулчих. 1 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Юуны түрүүн Байнгын хороон дарга болон Байнгын хорооны гишүүддээ талархал илэрхийлэх ёстой. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв дээр бас энэ хортон шавжтай тэмцэх 8 тэрбум төгрөгийг бол улсын төсөвт суулгаж өгсөн. Энэ бол маш том ажил. 2022 онд хортон шавжтай тэмцэх холбоо бүхий асуудал дээр тухайн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоо бүхий асуудлуудыг бид нар Авлигатай тэмцэх газартай хамтарч бас олон удаа хөндсөн нэг асуудлын нэг нь бол энэ байсан.

Үүний хүрээнд ч гэсэн бас дараа дараагийн шаталсан арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. Хортон шавжтай тэмцэх дээр 8 тэрбумаас гадна бид нар “Рио Тинто” компанитай байгуулсан 3 тэрбум нэмэгдээд 2023 оны хувьд бол 11 тэрбум төгрөгийг зарцуулахаар байгаа.

Гэхдээ энэ мөнгө бол ханаа ч хүрэхгүй. Өөрөөр хэлбэл яг өнөөдөр Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээр 735000 га газар ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн гэдэг ийм тооцоо, судалгааг бол олон улсын байгууллагатай хамтраад Байгаль орчин, аялал жуулчлалын яам өнгөрсөн 2022 онд бол хийсэн. 5 дугаар сард хийж дуусгасан. 2023 онд бид нар

үргэлжлүүлэн дахин судалгаа шинжилгээний ажлуудыг хийж байгаа.

2023 онд бол бид нар онгоцоор нийтдээ 145000 га газар гар аргаар бол 40000 га газар дээр ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хийхээр төлөвлөж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар хүлээсэн үүрэг аймаг орон нутгийн асуудал дотор байдаг. 2023 оны Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргадтай хамтран ажиллах гэрээн дээр бол Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар буюу төвлөрсөн орлогоос ой хөнөөлт шавжтай тэмцэх ажлуудыг шат дараалсан байдлаар хийх, төвлөрсөн орлогыг хууль бусаар зориулалтын бусаар өөр зүйлд зарцуулахгүй байх энэ чиг үүргийг бол мөн аймаг болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд бол өгсөн.

Ялангуяа өнөөдөр ой хөнөөлт шавжтай тэмцэх энэ төсвийн ажил бол Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар аймгийн сумдын өөрийн хийх ёстой ажлуудын 1 байдаг. 2022 он, 21 он, 2019 он гээд ингээд харахаар юу яах вэ шат дараалаад ингээд хэдийгээр өсөөд хэрэгжилт дээр шат дараалаад өсөөд явж байгаа боловч ерөөсөө 50 хуваас дээш гарч чадахгүй байгаа.

Тийм учраас бид нар Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйл дээр бол хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гэдэг ийм заалт байдаг. Энэ заалтыг бид нар ашиглаж байна. Улсын ерөнхий прокурорт бид нар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай холбоотой Улсын ерөнхий прокурорын албан даалгаврыг гаргуулах, мөн ойн сан, усан сан бүхий газарт холбогдох хууль тогтоомж зөрчиж үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих

хяналтыг сайжруулах гэх мэтчилний б зүйлээр Монгол Улсын ерөнхий прокурорт бид нар хандаад байна.

Бид нар энэ байгалийн нөөц эрхэлсний төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж чадахгүй байгаа тохиолдолд аймгийн удирдлагууд хууль бусаар, зориулалтын бусаар цагаан дээр хараар бичигдсэн энэ хуулийг зөрчсөөр байгаа тохиолдолд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил бол 100 хувь хийгдэхгүй. Энэ хуулиар төвлөрсөн орлогын яг ойн 85 хувийг бол буцаад ойд нь зарцуулах ийм зүйл заалттай.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан даалгавар гарсан. Ойн агентлагийн даргын тушаал гарсан. Бүх аймагт бас хүргэгдчихээд явж байгаа юм. Тэгэхээр 2023 оны 5 сараас авхуулаад зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам биш аймаг, нийслэлийн удирдлагууд өөрсдөө өөрсдийнхөө нутаг дэвсгэр дээр байгаа энэ ойн хөнөөлттэй шавжтай тэмцэх энэ ажлыг хийх ёстой. Тэр мөнгө нь аль хэзээний Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар өөрсдөд нь төвлөрчихсөн байгаа.

Тэгэхээр энийг бол би бас энэ Байнгын хорооны хурал дээр бас энэ аймаг, нийслэлийн удирдлагуудад хандаж хатуу хэлмээр байна.

Б.Саранчимэг: Хортон шавж дээрээ илүү сайн анхаарч, сүүлийн үеийн техник технологи бас тэр аргуудыг бас ашиглаарай. Гар арга аль хэр үр өгөөжтэй бол гэдэг дээр бас Тэмүүлэн гишүүн бас тодруулж хэлээрэй гэсэн шүү. Тэгэхээр энэ дээр бас хамтарч анхаарч ажиллаарай гэж хүсэж байна.

Тэгэхээр өнөөдрийн бас Байнгын хорооны хурал манай гишүүд ч хэлж байна протоколоороо үүрэг өгнө. Энэ сарын хугацаатай үүрэг өгч байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын гишүүн, мөн Байнгын хороо гэдэг бол өөрийнхөө Үндсэн хууль болоод мөн энэ Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын

Их Хурлын хууль, тогтоолын хэрэгжилтэд бид нар бас хяналт тавих бүрэн эрхтэй байдаг.

Тэгэхээрээ энэ дагуу бас ингээд Байнгын хороон дээрээ хэлэлцэгдээд ингээд явж байна. Тэгээд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг яагаад онцлоод хэлээд байна гэвэл бид нар өнөөдөр ганцхан бидний ногоон зүрх болсон ганц том Үндэсний цэцэрлэгт хүрээлэн. Энэ чинь цаашидаа дахиад тохижилт гэвэл ерөөсөө зам, хүмүүсийн дугуйгаа унадаг, алхдаг энэ зам, сандлуудыг л бас хийгээсэй гэж хүсэж байгаа. Ерөнхий төлөвлөгөөнд бол тийм л байгаа. Тэгээд хариулт нь болохоор ингээд зөрөөд, очихоор ингээд 40 түцтэй гэгчхээд яг бодит байдал дээрээ 81 түцтэй байх байдалтай байх жишээтэй.

Тэгэхээр ер нь зүгээр энийг жигдлэх, цэгцлэх цаг нь болчихсон. Бид нар ганц очдог цэцэрлэгт хүрээлэнгээ одоо хайрлаж хамгаалахгүй бол өө энэ чинь нэг Цэцэрлэгт хүрээлэнгийн даргын эрх, үүргийн дагуу ингээд хийгдчихсэн гэж болохгүй. Тийм эрх байхгүй шүү дээ. Тэнчээ KFC Land хийгдэнэ гэсэн ерөөсөө ерөнхий төлөвлөгөөнд ороогүй. Ажлын тохижилтын 30 га дээр ажлын зураг хийгдсэн тэрэнд ерөөсөө байхгүй байгаа. Тэр хүмүүсийг буруутгаж зөвшөөрөл өгч байгаа хүмүүс нь аягүй энийгээ өөрсдөө нэгэнт удирдаж явж байгаа бол энэ дээрээ анхааралтай ажиллах ёстой шүү дээ. Энэ архитектур үхчихсэн. Энэ тэрний буруу гэхээсээ илүү бид нар өнөөдөр л энийгээ цэгцэлж авахгүй бол цаашидаа манай энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэн олон байгууллагууд саналаа хэлдэг. Ямар ч шалгаруулалт байхгүй хоорондоо яриад л энэ ажлыг шийддэг. Үнэхээр харамсалтай байна.

Тэгэхээр энэ Байнгын хорооноос бол одоо энэ хувийн хэвилийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг ногоон байгууламж 85, 15 гэсэн харьцаатай Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үндсэн концепцтой уялдуулж, зураг төслийн

холбогдох хууль журмын дагуу батлуулж ажлыг нь хийлгэх. Одоо энэ KFC Land-д ч гэсэн яг энэ зургаар нь биш, хийгдэж байгаа газар нь 85 хувь нь ногоон байгууламж байхаар хийгээрэй.

Холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж олон нийтийн мэдээлэлд ил тод нээлттэй байлгах ийм үүрэг өгч байна.

Мөн цаашид иргэд хувийн хэвшилээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хийгдэх бүтээн байгуулалт, тохижилттой холбоотой асуудлыг хэрхэн яаж сонгон шалгаруулах, ямар хэмжээнд зөвшөөрөх, хэн яаж шийдвэрлэх асуудлыг маш тодорхой болгож зохицуулах эрх зүйн актыгаа тэгвэл боловсруулаадах. Боловсруулж, батлуулах хэрэгтэй.

Нөгөө талаар одоо байгаа энэ түүц, хөшөө дурсгалтай холбоотой асуудлыг дахин хянаж эдгээр асуудлыг цэгцлэх ажлыг яаралтай зохион байгуулах хэрэгтэй байна.

Нөгөө талаар энэ Засгийн газар, мөн манай хот, тэрбум мод, хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж гээд энэ олон ялангуяа энэ ногоон байгууламж дээрээ хамтарч, уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй байна. Түрүүн Дамдинням гишүүний асуултад ч гэсэн аягүй их тодорхой хариуллаа шүү дээ. Тэгэхээр энийгээ бид нар биш бид нар адилхан л энэ хөгжлийн төлөө хот хамтарч явж байгаа юм чинь энийгээ их зөв горимд нь зарчимтай яг бас хууль эрх зүйн хүрээнд нь хиймээр байгаа байхгүй юу. Тэгэхгүй дахиад нэг дуртай хүн нь орж ирчихдэг дахиад 2 дахь хааша барьчихсан байна гэж байна. Тэр дээрээ очиж дахиж хараарай. Хийчихсэн байгаа ногоон байгууламжийг устгаж болохгүй шүү. Очиж хяналт тавиад Төмөртөмөө дарга энэ дээр дахиж хариулт өгөөрэй гэж хүсье. Тэгээд хамгийн гол нь бид нар иргэдээс ирсэн энэ гомдлыг ногоон байгууламжаа сүйтгэж энэ Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн концепцыг алдагдуулж байна гэдэг дээр бид нар

нэгдэж байгаа учраас энэ дээр эргээд тэр төлөвлөлтөө өөрчлөөд, төлөвлөлт дээрээ анхаараад, эргэж хариу гурван 7 хоногийн үүрэг өгье протоколоор. Тэгэхээр энэ үүргүүдийг биелүүлээд энийгээ эргэж хариулахыг хүсэж байна.

12.34 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР